**АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ГАЗРЫН УДИРДЛАГЫН ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ШИЙДВЭР**

2025 оны 12 сарын 17 өдөр Дугаар 09 Улаанбаатар хот

# ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ ХЭЛЭЛЦЭХ ТУХАЙ

2025 оны 12 дугаар сарын 16-ны өдөр Улаанбаатар хот

Ашигт малтмал, газрын тосны газрын Удирдлагын зөвлөлийн 2025 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 09 дүгээр хуралдааны тэмдэглэлд:

Нэг. Хэлэлцсэн нь: Байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг хэлэлцэх тухай

Шийдвэрлэсэн нь: Ашигт малтмал, газрын тосны газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг 2025 оны жилийн эцсийн байдлаар Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан "Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам"-ын баримтлан үнэлсэн байна. Үүнд:

- Ашигт малтмал, газрын тосны газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний 37 зорилт, 83 арга хэмжээний биелэлт 2025 оны жилийн эцсийн байдлаар 93.61 хувьтай үнэлэгдсэн байна.

Ашигт малтмал, газрын тосны газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг 2025 оны жилийн эцсийн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнг хэлэлцэж, Ашигт малтмал, газрын тосны газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын үнэлгээгээр Аж үйлдвэр, эрдэс баялгийн яаманд хүргүүлэхийг Удирдлагын зөвлөлийн дарга, гишүүд зуун хувийн (100%) саналаар дэмжив.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ П.БАЯНБААТАР

5323533 C1C4335 9023070078

15?5300030

# АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ГАЗРЫН 2025 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Тайлан баталгаажуулсан: *Төсвийн Ерөнхийлөн захирагч*

АЖ ҮЙЛДВЭР, ЭРДЭС БАЯЛГИЙН САЙД /Г.ДАМДИННЯМ/

..............................
*(огноо)*

Тайлагнасан: *Төсвийн Шууд захирагч*

АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ГАЗРЫН ДАРГА /П.БАЯНБААТАР/

2025.12.17
*(огноо)*

## АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ГАЗРЫН 2025 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАНИЛЦУУЛГА

/2025 оны жилийн эцсийн байдлаар/

2025.12.17 Улаанбаатар хот

### Нэг. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ЗОРИЛГО

Монгол Улсын Төрийн албаны тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.1 болон Засгийн газрын 2020 оны 217 дугаар тогтоолоор баталсан "Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам"-ын дагуу Аж үйлдвэр, эрдэс баялгийн асуудал эрхэлсэн Төсвийн ерөнхийлөн захирагчийн баталсан Ашигт малтмал, газрын тосны газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийж, гүйцэтгэлийн зорилтот түвшинг хүрсэн түвшинтэй нь харьцуулан үр дүнг үнэлэх, дүгнэлт, зөвлөмж боловсруулах, удирдлагыг үнэн зөв мэдээллээр хангах, цаашид төлөвлөсөн зорилтыг бүрэн биелүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд оршино.

### Хоёр. ХЯНАЛТ- ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ АРГА ЗҮЙ

Ашигт малтмал, газрын тосны газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний 4.9.1, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний 3.2.1, Засгийн газрын 2020 оны 217 дугаар тогтоолоор батлагдсан Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журмын 4.7-д “Байгууллагын захиргаа, хүний нөөцийн асуудал хариуцсан нэгж байгууллагын гүйцэтгэлийн тайланг нэгтгэх бөгөөд хяналт-шинжилгээ, үнэлгээний нэгж түүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ” гэж заасны дагуу байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлээ.

Гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхдээ Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам”-ыг баримталж ажиллав.

Байгууллагын төлөвлөсөн үйл ажиллагааны 37 зорилт, 83 арга хэмжээний урьдчилан тодорхойлсон шалгуур үзүүлэлтийн дагуу зорилтот түвшинд хүрч байгаа эсэхэд дүн шинжилгээ хийж, хүрээгүй бол шалтгаан нөхцөлийг тодорхойлж, үр дүнг сайжруулах дүгнэлт, зөвлөмж гарган хяналт-шинжилгээ, үнэлгээг хийсэн болно.

Ашигт малтмал, газрын тосны газар 2023 оноос Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим сан, Гүйцэтгэлийн удирдлагын мэдээллийн цахим санг үйл ажиллагаандаа нэвтрүүлэн ажиллаж байна. Тус систем нь Засгийн газрын 2023 оны 301 дүгээр тогтоолоор баталсан журам, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2023 оны 98 дугаар тушаалын хавсралтаар баталсан загварын дагуу байгууллага, бүтцийн нэгж, албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг төлөвлөж, тайлагнахаар программчлагдсан.

Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд туссан арга хэмжээг агентлагийн зохион байгуулалтын бүтцийн нэгжүүдэд оновчтой хуваарилан төлөвлөх, хэрэгжилтийг хангаж ажиллах чиглэлд төлөвлөлт, тайлагналтын шатанд алдаа гаргахгүй байх зорилгоор Гүйцэтгэлийн удирдлагын мэдээллийн цахим санд “Байгууллага - Нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний уялдаа” цэсээр дамжуулан

хянаж ажилласан. Ингэхдээ байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд туссан арга хэмжээг зохион байгуулалтын бүтцийн нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд уялдуулж, нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгах чиглэлд “Нэгж - албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний уялдаа” цэсийг ажиллуулж дээрээс доош чиглэсэн төлөвлөлтийг хийсэн.

### Гурав. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН

Төсвийн шууд захирагч нь байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан нийт 37 зорилтын 83 арга хэмжээг агентлагийн 15 бүтцийн нэгжийн үндсэн чиг үүргийн дагуу хуваарилан хэрэгжилтийг зохион байгуулж ажилласан.

**АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ГАЗРЫН 2025 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ДҮН**

Хүснэгт-1

| № | Зорилтын нэр | Үүнээс | | | | | | | | Дундаж |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | 100% | 90% | 70% | 50% | 30% | 0% | 100>... >90 | 90>... >70 | |
| 1 | Нэг. Хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ | 6 | 8 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 94.28% |
| 2 | Хоёр. Хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ | 2 | 1 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 96.66% |
| 3 | Гурав. Хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ | 15 | 25 | 2 | 0 | 0 | 0 | 2 | 0 | 92.61% |
| 4 | Гурав. Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ | 13 | 7 | 1 | 0 | 0 | 0 | 0 | 1 | 95.23% |
| | **НИЙТ** | **36** | **41** | **3** | **0** | **0** | **0** | **2** | **1** | **93.61%** |

**Нийт үнэлгээг арга хэмжээний дунджаар тооцсон болно.*

### Дөрөв. ДҮГНЭЛТ

4.1. Аж үйлдвэр, эрдэс баялгийн асуудал эрхэлсэн Төсвийн ерөнхийлөн захирагчийн баталсан Ашигт малтмал, газрын тосны газрын 2025 оны гүйцэтгэлийн тайлангийн биелэлт нь жилийн эцсийн байдлаар **93.61** хувиар үнэлэгдэж, өмнөх жилийн гүйцэтгэлийн үнэлгээнээс 0.28 хувиар өссөн байна.

4.2. Ашигт малтмал, газрын тосны газрын 2025 оны гүйцэтгэлийн тайлангийн үнэлгээнд хамрагдсан 37 зорилт, 83 арга хэмжээнээс 100 хувийн биелэлттэй 36, 90 хувийн биелэлттэй 41, 70 хувийн биелэлттэй 3 арга хэмжээ байна.

4.3. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд туссан арга хэмжээг агентлагийн зохион байгуулалтын бүтцийн нэгжүүдэд оновчтой хуваарилан төлөвлөх, хэрэгжилтийг хангаж ажиллах чиглэлд төлөвлөлт, тайлагналтын шатанд алдаа гаргахгүй байх зорилгоор Гүйцэтгэлийн удирдлагын мэдээллийн цахим санд "Байгууллага - Нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний уялдаа" цэсээр дамжуулан хянаж, дээрээс доош чиглэсэн төлөвлөлтийг хийсэн нь төлөвлөлт, гүйцэтгэл, хяналт-шинжилгээ, үнэлгээний шатанд гарах алдааг багасгаж, гүйцэтгэлийн дүн өмнөх оноос өсөхөд нөлөөлсөн байна.

**Тав. ЗӨВЛӨМЖ**

5.1. Ашигт малтмал, газрын тосны газрын 2026 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд газар, хэлтсүүдийн хариуцан хэрэгжүүлэхээр тусгах зорилт, арга хэмжээг төлөвлөхдөө бүтцийн нэгжийн хөгжлийн бодлогын баримт бичиг, хуулиар тусгайлан олгосон чиг үүрэг, АМГТГ-ын стратеги төлөвлөгөө, стратеги бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөртэй уялдуулан төлөвлөхийг бүх нэгжийн дарга нарт;

5.2. АМГТГ-ын 2026 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд туссан зорилт, арга хэмжээг зохион байгуулалтын бүтцийн нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд бүрэн тусгаж, хэрэгжилтийг хангаж ажиллахыг бүх нэгжийн дарга нарт;

5.3. Гүйцэтгэлийн төлөвлөгөөний зорилт, арга хэмжээний суурь түвшин, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин, хэрэгжүүлэх хугацааг холбогдох журам, аргачлалд заасан төлөвлөлтийн шаардлагад нийцүүлж боловсруулахыг нэгжийн дарга, албан хаагчдад;

5.4. Байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн үнэлгээгээр хэрэгжилт хангалтгүй болон хэрэгжээгүй арга хэмжээг байгууллагын 2026 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаж ажиллахыг холбогдох нэгжийн дарга нарт, хэрэгжилтийг хангуулах чиглэлд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газарт;

5.5. Холбогдох нэгжүүд хэрэгжүүлж буй арга хэмжээний үр дүнг тайлант хугацааны гүйцэтгэлээр бий болсон явцын ахиц өөрчлөлтийн талаар тайландаа бүрэн тусгах чиглэлд анхаарч ажиллахыг нэгжийн дарга, албан хаагчдад тус тус зөвлөмж болгож байна.

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2020 оны 100 дугаар тушаалын
7 дугаар хавсралт

## АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ГАЗРЫН 2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ

Хүснэгт 2

| № | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэтгэл -ийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| Нэг. Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт, арга хэмжээ | | | | | | | |
| 1.1. | Оюутолгойтой дүйцэхүйц дараагийн стратегийн бүтээн байгуулалтыг эхлүүлнэ. | Үйл ажиллагааны зардлаар | Шаардлагатай мэдээлэл хүргүүлсэн эсэх | Үгүй | Тийм | Цагаансуваргын зэс молибдений ордод хэрэгжүүлэх арга хэмжээний 2025 оны биелэлт болон эдийн засгийн эргэлтэд оруулах төслийн танилцуулга бэлдэж Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Эрдэс баялгийн бодлогын газарт хүргүүлсэн. | 90% |
| 1.1.1 | Цагаансуваргын зэс молибдений ордыг эдийн засгийн эргэлтэд оруулахад шаардлагатай мэдээ мэдээллээр Засгийн газар, яам, төрийн байгууллагуудыг хангах | Үйл ажиллагааны зардлаар | Шаардлагатай мэдээлэл хүргүүлсэн эсэх | Үгүй | Эхний хагас жилд: Тийм Жилийн эцэст: Тийм | Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан Цагаансуваргын зэс молибдений ордод хэрэгжүүлэх арга хэмжээний 2025 оны жилийн эцсийн биелэлт болон хийгдсэн ажлын танилцуулга, ордын эдийн засгийн эргэлтэд оруулах төслийн танилцуулга бэлдэж Аж үйлдвэр, эрдэс баялгийн яаманд хүргүүлсэн.<br>Хүрсэн түвшин: Тийм | 90% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1.2. | Газрын ховор элемент боловсруулах үйлдвэрийн төслүүдийг бодлогоор дэмжинэ. | Үйл ажиллагааны зардлаар | 1.Холбогдох ажлыг зохион байгуулсан эсэх 2.Судалгаа хийсэн эсэх | Үгүй | 1. Тийм 2. Тийм | Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн 2 удаагийн салбар хуралдаанаар Хөтөл улаан лити, рубидийн ордыг ил болон далд аргаар ашиглах техник, эдийн засгийн үндэслэл, Уртын цагаан чулуут литийн ордыг ил аргаар ашиглах, хүдрийг хөвүүлэн баяжуулах аргаар баяжуулах техник-эдийн засгийн үндэслэлийг хэлэлцэж хүлээн авч дүгнэлт тушаалыг гаргасан. | 90% |
| 1.2.1 | Газрын ховор элементийн ордын техник, эдийн засгийн үндэслэлийг ЭБМЗ-өөр хэлэлцүүлэх, төрийн захиргааны байгууллагын бүртгэх, шийдвэр гаргуулах ажлыг зохион байгуулах | Үйл ажиллагааны зардлаар | 1.ТЭЗҮ ирүүлсэн эсэх 2.Тушаал гарсан эсэх | Үгүй | Эхний хагас жилд: 1.Тийм 2.Тийм Жилийн эцэст: 1.Тийм 2.Тийм | Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн 2025 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн салбар хуралдаанаар Дорноговь аймгийн Даланжаргалан сумын нутагт орших Хөтөл улаан лити, рубидийн ордыг ил болон далд аргаар ашиглах техник, эдийн засгийн үндэслэлийг хэлэлцэж хүлээн авч дүгнэлт тушаалыг гаргасан. Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн 2025 оны 04 дүгээр сарын 10-ны өдийн 08 дугаар салбар хуралдаанаар Төв аймгийн Эрдэнэ сумын нутагт орших Уртын цагаан чулуут литийн ордыг ил аргаар ашиглах, хүдрийг хөвүүлэн баяжуулах аргаар баяжуулах техник-эдийн засгийн үндэслэлийг хэлэлцэж хүлээн авч дүгнэлт тушаалыг гаргасан.<br>Хүрсэн түвшин: 1.Тийм 2.Тийм | 90% |
| 1.2.2 | Газрын ховор элементийн олборлолт, баяжуулалт, боловсруулалтын төслүүдийн бүтээгдэхүүн гаргалт, эдийн засгийн үр өгөөж | Үйл ажиллагааны зардлаар | Судалгаа хийсэн эсэх | Үгүй | Эхний хагас жилд: - Жилийн эцэст: Тийм | Олон улсын газрын ховор элементийн зах зээлийн өнөөгийн байдал, хэтийн төлөв, Монгол улсын газрын ховор элементийн хайгуул, ашиглалтын байдлыг судалж, ирээдүйд газрын ховор элементийн олборлолт, баяжуулалт, боловсруулалтын төслүүдээс гарах | 90% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | зэрэг үзүүлэлтээр хэтийн төлөвийн судалгаа хийх | | | | | бүтээгдэхүүн, эдийн засгийн үр өгөөж, ажлын байр үзүүлэлтүүдийг нэгтгэн боловсруулж "Монгол улсын газрын ховор элементийн хэтийн төлөвийн судалгаа"-г хийж, судалгааны ажлын тайланг Аж үйлдвэр, эрдэс баялгийн яаманд хүргүүлсэн.<br>Хүрсэн түвшин: Тийм | |
| 1.3. | Алтны олборлолтыг нэмэгдүүлэх ба алт цэвэршүүлэх үйлдвэр барина. | Үйл ажиллагаа ны зардлаар | Шаардлагатай мэдээлэл хүргүүлсэн эсэх | Үгүй | Тийм | Үйл ажиллагааны хөтөлбөрийн бодлогын үндсэн 4 чиглэлийн хүрээнд хэрэгжүүлэх алт цэвэршүүлэх үйлдвэр байгуулах 14 мега төсөлд шаардлагатай алтны / үндсэн, шороо, үүсмэл/ ордуудын үлдэгдэл нөөцийн мэдээллийг бэлтгэн Аж үйлдвэр, эрдэс баялгийн яаманд хүргүүлсэн. | 90% |
| 1.3.1 | Гурваас доошгүй алтны үндсэн ордыг эдийн засгийн эргэлтэд оруулахад шаардлагатай мэдээ мэдээллээр Засгийн газар, яам, төрийн байгууллагуудыг хангах | Үйл ажиллагаа ны зардлаар | Шаардлагатай мэдээлэл хүргүүлсэн эсэх | Үгүй | Эхний хагас жилд: Тийм Жилийн эцэст: Тийм | 1. Үйл ажиллагааны хөтөлбөрийн бодлогын үндсэн 4 чиглэлийн хүрээнд хэрэгжүүлэх алт цэвэршүүлэх үйлдвэр байгуулах 14 мега төсөлд шаардлагатай алтны / үндсэн, шороо, үүсмэл/ ордуудын 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийн байдлаар үлдэгдэл нөөцийн мэдээллийг бэлтгэн Аж үйлдвэр, эрдэс баялгийн яаманд хүргүүлсэн. 2. Засгийн газарт танилцуулахаар хүчин төгөлдөр болон цуцлагдсан ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй алтны үндсэн ордын нөөцийн мэдээлэл бэлтгэн Хайгуул, ашиглалтын газрын даргад хүргүүлсэн.<br>Хүрсэн түвшин: Тийм | 90% |
| 1.4. | “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг эрчимжүүлэх, хэрэгжүүлж ажиллана. | Үйл ажиллагаа ны зардлаар | Хэрэгжилт хангагдсан эсэх | Тийм | Тийм | 2025 оны жилийн эцсийн байдлаар “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд 1,439.9 га талбайд 2,6 сая ширхэг мод тарьсан байна. | 90% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1.4.1 | 2024 оны тайлан болон 2025 оны төлөвлөгөөнд тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд авч хэрэгжүүлсэн болон авч хэрэгжүүлэх арга хэмжээг тусгуулах, тухайн мэдээллээр холбогдох байгууллагуудыг хангаж ажиллах. | Үйл ажиллагаа ны зардлаар | 1. Хянасан тайлангийн тоо 2. Төлөвлөгөөнд тусгасан эсэх | 1. 194 2. Тийм | Эхний хагас жилд: 1. Тайлангийн тоо 2. Тийм Жилийн эцэст: 1. Тайлангийн тоо 2. Тийм | 1. 2025 онд “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд 1,439.9 га талбайд 2,6 сая ширхэг мод тарьсан байна. 2. 2025 оны төлөвлөгөөнд техникийн нөхөн сэргээлтийг 6,989.8 га талбайд, биологийн нөхөн сэргээлтийг 2275.2 га талбайд, дүйцүүлэх хамгаалах ажлыг 128,821.0 га талбайд нөхөн сэргээлт хийхээр, “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд 2025 онд 22,864.8 га талбайд 2.1 сая мод тарихаар тусгуулан ажиллалаа.<br>Хүрсэн түвшин: 1. 123 2. Тийм | 90% |
| 1.5. | Зөөвч-Овоо, Дулаан уулын ураны ордыг ашиглах хөрөнгө оруулалтын гэрээг байгуулна. | Үйл ажиллагаа ны зардлаар | Шаардлагатай мэдээлэл хүргүүлсэн эсэх | Үгүй | Тийм | 1.Ашигт малтмал, газрын тосны газар болон “Бадрах энержи” ХХК-ийн хооронд 2016 оны 09 дүгээр сарын 15-ны өдөр байгуулсан Орд ашиглах гэрээний хэрэгжилтийг дүгнэх тухай ажлын хэсэгт ажиллаж гэрээний хэрэгжилтийг дүгнэж, гаргасан дүгнэлт, зөвлөмжийг Бадрах энержи ХХК-д хүргүүлсэн. 2.Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын 2025 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн А/50 дугаар тушаалаар Зөөвч овоо, Дулаан уулын ордыг ашиглах гэрээний шинэчилсэн төслийг боловсруулах ажлын хэсэг байгуулагдаж өмнөх гэрээний хэрэгжилтийн талаар ажлын хэсэгт танилцуулж, Орд ашиглах гэрээний шинэчилсэн төслийг боловсруулж, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Удирдлагын зөвлөлөөр хэлэлцүүлсэн. | 90% |
| 1.5.1 | Орано майнинг компанитай хөрөнгө оруулалтын гэрээг | Үйл ажиллагаа | Шаардлагатай мэдээлэл хүргүүлсэн эсэх | Үгүй | Эхний хагас жилд: Тийм | 1.Монгол улсын Засгийн газрын хэрэг эрхлэх газрын даргын 2023 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн 97 дугаар | 90% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | байгуулах болон Зөөвч овоо, Дулаан уулын ордын ашиглалтад бэлтгэхэд шаардлагатай мэдээ мэдээллээр хангаж ажиллах | ны зардлаар | | | Жилийн эцэст: Тийм | тушаалаар байгуулагдсан Монгол, Францын хамтарсан “Бадрах энержи” ХХК-ийн хөрөнгө оруулагч Орано Майнинг ирүүлсэн “Хөрөнгө оруулалтын гэрээний” төслийг Монгол улсын Үндсэн хууль, олон улсын гэрээ, холбогдох хууль тогтоомжийн хүрээнд судалж санал дүгнэлт боловсруулах, хөрөнгө оруулагчтай талтай хэлэлцээ хийх, төслийг тохирох, эцэслэсэн хувилбарыг Засгийн газрын хуралдаанд танилцуулах үүрэг бүхий ажлын хэсэгт хүргүүлсэн. Хөрөнгө оруулалтын гэрээ 2025 оны 01 дүгээр сарын 17-ны өдөр байгуулагдсан. 2. Хөрөнгө оруулалтын гэрээ байгуулагдсантай холбогдуулан Бадрах энержи ХХК-тай 2016 оны 09 дүгээр сарын 15-ны өдөр байгуулсан Орд ашиглах гэрээг шинэчлэн байгуулах шаардлага гарсан. Орд ашиглах гэрээний төслийг шинэчлэн боловсруулж, гэрээний төслийг Засгийн газрын хуралдаанд танилцуулах, гэрээ байгуулах ажлын зохион байгуулж ажиллаж байна.<br>Хүрсэн түвшин: Тийм | |
| 1.5.2 | Газар доор уусган баяжуулах техник технологийн судалгаа хийж, үнэлэлт, дүгнэлт өгөх, төслийн дэд бүтцийн боломжийг судлах, дэмжлэг үзүүлэн ажиллах | Үйл ажиллагаа ны зардлаар | 1.Судалгаа хийсэн эсэх 2.Үнэлэлт өгсөн эсэх | Үгүй | Эхний хагас жилд: 1.Тийм 2.Тийм Жилийн эцэст: 1.Тийм 2.Тийм | Бадрах энержи ХХК-тай урьдчилсан байдлаар уулзалт зохион байгуулж, "Газар доор уусган баяжуулах техник технологийн судалгаа хийж, үнэлэлт, дүгнэлт өгөх, төслийн дэд бүтцийн боломжийг судлах" чиглэлээр Ашигт малтмал, газрын тосны газар ахалж, холбогдох байгууллагууд оролцсон ажлын хэсгийг байгуулан, төлөвлөгөө гаргаж ажиллахаар зөвшилцөв. | 90% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Хүрсэн түвшин: 1.Тийм 2.Тийм | |
| 1.6. | Уул уурхайн салбарын түүхий эдийн боловсруулалтын түвшин болон хүнд үйлдвэрлэлийн хүчин чадлыг өсгөж, экспортын орлогыг нэмэгдүүлнэ. | Үйл ажиллагааны зардлаар | Шаардлагатай мэдээлэл хүргүүлсэн эсэх | Үгүй | Тийм | Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутагт байгуулагдах катодын зэсийн үйлдвэрийн техник эдийн засгийн үндэслэлийг хэлэлцэх ЭБМЗ-ийн өргөтгөсөн хуралдаанд оролцож мэдээллээр хангаж ажилласан. | 90% |
| 1.6.1 | Уул уурхайн гаралтай бүтээгдэхүүний боловсруулалтын түвшинг нэмэгдүүлэхэд шаардлагатай мэдээ мэдээллээр хангаж ажиллах | Үйл ажиллагааны зардлаар | Шаардлагатай мэдээлэл хүргүүлсэн эсэх | Үгүй | Эхний хагас жилд: Тийм Жилийн эцэст: Тийм | Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутагт байгуулагдах катодын зэсийн үйлдвэрийн техник эдийн засгийн үндэслэлийг хэлэлцэх ЭБМЗ-ийн өргөтгөсөн хуралдаанаар хэлэлцүүлж ажилласан.<br>Хүрсэн түвшин: Тийм | 90% |
| 1.7. | Газрын тосны бүтээгдэхүүний нийлүүлэлт, хангамжийн тогтвортой байдлыг хангах, К-5/Евро-5/ стандартын шатахууны импорт, хэрэглээг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулна. | Үйл ажиллагааны зардлаар | 1. Нийт шатахууны хэмжээ сая тонн 2. К5/Евро-5/ шатахууны эзлэх хувь 3. Нэг маягийн зураг төсөл боловсруулах ажлын гүйцэтгэл хувиар | 1. 2.5 сая тонн 2. 15 хувь 3. 0 хувь | 1. 2.6 сая тонн 2. 17 хувь 3. 100 хувь | - Улсын хэмжээнд 2025 оны жилийн эцсийн байдлаар нийт 2.6 сая тонн шатахуун импортлон хэрэглэснээс К-5/Евро-5/ стандартын шатахуун 467 мянган тонн буюу нийт шатахууны 18 хувийг эзэлж, зорилтот түвшиндээ хүрсэн. - Манай гол ханган нийлүүлэгч орнууд болох ОХУ-ын дотоодын зах зээлийн нөхцөл байдал дэлхийн зах зээл дэх газрын тос болон газрын тосны бүтээгдэхүүний үнийн хэлбэлзэл зэрэг гадаад хүчин зүйлсийн нөлөө их байсан хэдий ч 2025 онд К-5 /Евро-5/ стандартын шатахууны хувь хэмжээг нэмэгдүүлэх хүрээнд БНХАУ-ын Петрочайна итнэрнэшнл компаниас тус ангиллын шатахуун импортлох талаар гэрээ, хэлцэл хийж, шаардлагатай арга хэмжээг тухай бүр авч ажилласан. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1.7.1 | Газрын тосны бүтээгдэхүүний нийлүүлэлт, хангамжийн тогтвортой байдлыг хангах ажлыг холбогдох талуудтай хамтран зохион байгуулах | - | Газрын тосны бүтээгдэхүүний импорт, хэрэглээний хэмжээ, /тонн/ | 2024 онд 2.5 сая тонн | Эхний хагас жилд: 1.3 сая тонн Жилийн эцэст: 2.6 сая тонн | Улсын хэмжээнд 2025 оны жилийн эцсийн байдлаар нийт 2.8 сая тонн газрын тосны бүтээгдэхүүн импортлоод байгаа ба зорилтот түвшин болох 2.6 сая тонноос 200 мян.тн-оор илүү байна. Импортын хэмжээг өнгөрсөн онтой харьцуулахад 1 хувиар өссөн үзүүлэлттэй байгаа ба бүтээгдэхүүний төрлөөр авч үзвэл Аи-92 автобензин 7 хувиар буурч, дизель түлш 7 хувиар өссөн байна.Өсөн нэмэгдэж буй хэрэглээг тогтвортой хангах хүрээнд нийлүүлэлтийг нэмэгдүүлэх чиглэлээр манай гол ханган нийлүүлэгч ОХУ-ын нийлүүлэгч талуудтай хэлэлцэн, импортын хэмжээг нэмэгдүүлэх арга хэмжээг авч, тус улсын Роснефть компанитай тогтмол харилцаатай ажиллаж, манай улсад нийлүүлэхээр илгээсэн газрын тосны бүтээгдэхүүний ачилтын болон вагоны мэдээг хүлээн авч, сар бүрийн импорт, дараа сарын захиалгын хэмжээнд тухай бүр хяналт тавьж, холбогдох арга хэмжээ авч ажилласан.<br>Хүрсэн түвшин: 2.8 сая тонн | 100% |
| 1.7.2 | Экологийн өндөр ангилал бүхий К5/Евро-5/ стандартын шатахууны импорт, хэрэглээг нэмэгдүүлэх ажлыг холбогдох талуудтай хамтран зохион байгуулах | - | Нийт шатахуунд эзлэх К5/Евро-5/ стандартын шатахууны хэмжээ, /хувь/ | 15 хувь | Эхний хагас жилд: 10 хувь Жилийн эцэст: 17 хувь | - Улсын хэмжээнд 2025 оны жилийн эцсийн байдлаар нийт 2.6 сая тонн шатахуун импортлон хэрэглэснээс К-5/Евро-5/ стандартын шатахуун 467 мянган тонн буюу нийт шатахууны 18 хувийг эзэлж, зорилтот түвшиндээ хүрсэн. - Манай гол ханган нийлүүлэгч орнууд болох ОХУ-ын дотоодын зах зээлийн нөхцөл байдал дэлхийн зах зээл дэх газрын тос болон газрын тосны бүтээгдэхүүний үнийн хэлбэлзэл зэрэг | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | гадаад хүчин зүйлсийн нөлөө их байсан хэдий ч 2025 онд К-5 /Евро-5/ стандартын шатахууны хувь хэмжээг нэмэгдүүлэх хүрээнд БНХАУ-ын Петрочайна итнэрнэшнл компаниас тус ангиллын шатахуун импортлох талаар гэрээ, хэлцэл хийж, шаардлагатай арга хэмжээг тухай бүр авч ажилласан.<br>Хүрсэн түвшин: 18 хувь | |
| 1.7.3 | Улсын нөөцийн шатахуун хадгалах агуулахын барилга байгууламж барих ажлын хүрээнд холбогдох тооцоо, судалгаа хийх, нэг маягийн зураг төсөл боловсруулахад шаардагдах судалгаа мэдээллээр хангах | Улсын төсөв, бусад эх үүсвэр | Нэг маягийн зураг төсөл | 0 хувь | Эхний хагас жилд: 50 хувь Жилийн эцэст: 100 хувь | Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн 3.3.1.9-д "Газрын тосны бүтээгдэхүүний 3-6 сарын хэрэглээний нөөц бүрдүүлэхэд шаардлагатай улсын нөөцийн шатахууны агуулахын барилга байгууламжийг ашиглалтад оруулна." гэж тусгагдсан. Тус ажлын хүрээнд УУХҮЯ-ны төрийн нарийн бичгийн даргын (хуучин нэрээр) тушаалаар батлагдсан ажлын хэсгийн бүрэлдэхүүнд ажиллаж, газрын тосны бүтээгдэхүүний улсын нөөцийн агуулахын байршил, төлөвлөлт, төсөв, улсын нөөц хадгалах агуулах барих нэг маягийн (жишиг) зураг төсөл боловсруулах ажлын даалгавар боловсруулж, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны төрийн нарийн бичгийн даргаар батлуулав. Батлагдсан ажлын төсөл Төрийн худалдан авах ажиллагааны газраас ЭЗХЯ/20240103158 дугаартай тендер зарлагдсан болно. Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамнаас “Төрийн худалдан авах ажиллагааны газраас зохион байгуулсан сонгон шалгаруулалтад шалгарсан аж ахуйн нэгж нь хуулийн | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хугацаанд гэрээ байгуулж амжаагүйн улмаас тендер шалгаруулалт хүчингүй болсон тул энэхүү асуудалтай холбоотой газрын тосны бүтээгдэхүүний улсын нөөцийн агуулахын жишиг нэг маягийн зураг төсөв боловсруулах ажлын даалгаврын дагуу дахин сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулах талаар" 2025 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 02/99 дугаартай албан бичиг Эдийн засаг, хөгжлийн яаманд хүргүүлсэн. 2025-10 -27-ны өдрийн А/152 дугаар тушаалаар Монгол Улсын тэргүүн шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын шийдвэрээр байгуулагдсан "Рашаант дахь Улсын нөөцийн агуулах төсөл"-ийн концессын гэрээг цуцлахтай холбоотой, концесс эзэмшигчид шилжүүлсэн газар эзэмших эрх болон өмч хөрөнгийг төрийн өмчид шилжүүлэн авах чиг үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүнд ажиллав. Уг чиг үүргийн хүрээнд АМГТГ нь 2025 оны 11 дүгээр сарын 07-ны өдрийн 1/5512 дугаартай албан бичгээр Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүргийн 21 дүгээр хороо, Рашаант өртөөний нутаг дэвсгэрт байрлах 8 га газрын эзэмших эрхийг АМГТГ-т шилжүүлэх тухай санал, хүсэлтийг холбогдох байгууллагад хүргүүлсэн.<br>Хүрсэн түвшин: 100 хувь | |
| 1.7.4 | Газрын тосны бүтээгдэхүүний хангамжийн болон агуулах, түгээх станцын нэгдсэн мэдээллийн сан | 19.3 сая төгрөг | Мэдээллийн сан | - | Эхний хагас жилд: 50 хувь Жилийн | Монгол Улсын шатахууны хангамжийн тогтвортой байдлыг хангах зорилтын хүрээнд газрын тосны бүтээгдэхүүний импорт, үлдэгдэл, нөөц болон үнийн мэдээллийг хүлээн авах | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | бий болгох, баяжуулах, мэдээллээр хангах | | | | эцэст: 100 хувь | mpetro.mrpam.gov.mn хангамжийн мэдээллийн цахим системд хөгжүүлэлт хийхээр 2025 оны 06 дугаар сарын 02-ны өдөр “Ажлын даалгавар”-ыг баталсан. Ажлын даалгаварт заасны дагуу системийн хөгжүүлэлт, шинэчлэлтийн ажлыг нийт 19.5 сая төгрөгийн санхүүжилтээр гүйцэтгэхээр төлөвлөсөн. Тус төсөв нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн босго үнээс бага тул шууд гэрээ байгуулах аргаар үнийн санал авч, хамгийн бага үнийн санал ирүүлсэн “Ухаалаг шийдэл” ХХК-ийг гүйцэтгэгчээр сонгон, 2025 оны 06 дугаар сарын 09-ний өдөр 2025/108 дугаартай “Ажил гүйцэтгэх гэрээ”-г байгуулсан. Гэрээнд тусгагдсан ажлуудыг дараах байдлаар гүйцэтгэсэн: 1. Шатахууны нэр төрөл, үнийн мэдээллийн бүтэц шинэчлэлт хийх хүрээнд К5/Евро-5/ ангиллын Аи-92 автобензин болон дизель түлшний нэр төрлийг системд шинээр нэмж оруулсан. Жижиглэнгийн үнийн мэдээлэл бүртгэх талбаруудыг нэмэн хөгжүүлж, мэдээллийн бүтцийг сайжруулсан. 2. Мэдээллийн модульд нэмэлт талбарууд оруулах хүрээнд бүх төрлийн шатахууны үлдэгдэл, бөөний болон жижиглэн борлуулалт, үйлдвэрлэл, шатдаг хийн мэдээний хэсэгт шаардлагатай нэмэлт талбаруудыг боловсруулж нэмсэн. 3. Хайлтын системийн өргөтгөл ба тайлан татах боломжийн хүрээнд аж ахуйн нэгжээр, он, сараар, тусгай зөвшөөрлийн төрлөөр, аймаг/хот болон сумын | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | түвшинд ангилан хайлт хийх боломжийг шинээр бүрдүүлсэн. 4. Хайлтын үр дүнг Excel формат-аар татаж авах боломжийг нэмж хөгжүүлсэн. 5. Хяналтын самбарын шинэчлэлт хийх хүрээнд системийн хяналтын самбар (dashboard)-т шаардлагатай шинэ мэдээлэл, статистикуудыг нэмж оруулсан. Одоогийн мэдээллийн үзүүлэлтийг шинэчлэн сайжруулсан. Гүйцэтгэлийн ажлуудыг бүрэн дуусгаж, хаалтын тайлан болон актыг холбогдох горимын дагуу боловсруулан хүлээн авсан.<br>Хүрсэн түвшин: 100 хувь | |
| 1.7.5 | Газрын тосны бүтээгдэхүүний улсын болон компанийн нөөц бүрдүүлэлтэд хяналт тавих, мэдээллээр хангах | - | Хяналт хийсэн тоо | - | Эхний хагас жилд: 6<br>Жилийн эцэст: 12 | - Монгол Улсын Засгийн газрын Эрсдэлийн сан болон 2012 оны улсын төсвийн хөрөнгөөр нийт 12,731.3 тн шатахууныг улсын нөөцөд бүрдүүлснээс 10,191.7 тонн нь зуны дизель түлш 2,539.5 тонн нь Аи-92 автобензин байгаа бөгөөд энэхүү улсын нөөцийн шатахууныг НИК, Монсуль, М-Ойл, Ойн бирж, Магнай трейд, Сод Монгол Групп, Петрохаан, Газойл нефть, Тод Петролиум, Шинэ эрин ойл, Шингэн түлш, Шилжүүлэн ачих байгууламж зэрэг 11 аж ахуйн нэгжид хүлээлгэн өгч, сэлгэх гэрээг шинэчлэн байгуулсан.Засгийн газрын 2025 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 34 дүгээр тогтоолоор “Газрын тосны бүтээгдэхүүний улсын нөөцийг сэлгэн хадгалах гэрээ”-ний дагуу хадгалж буй нэр бүхий аж ахуйн нэгжүүдээс улсын нөөцийн 5191.6 тонн дизель түлшийг буцаан авах, худалдан борлуулах, | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | худалдан борлуулсан орлогоос агаарын хөлгийн ТС-1 түлшний улсын нөөц бүрдүүлэхийг үүрэг болгосон. Үүний дагуу НИК, Монсуль, М-Ойл, Ойн бирж, Магнай трейд, Сод Монгол Групп, Петрохаан, Газойл нефть зэрэг 7 аж ахуйн нэгжээс тус дизель түлшийг “Эрчис Ойл” ХХК-д шилжүүлж, ТС-1 онгоцны түлшний нөөц бүрдүүлэх ажил хийгдсэн. - "Газрын тосны бүтээгдэхүүний улсын нөөцийг сэлгэн хадгалах гэрээ"-ээр улсын нөөцийн шатахууныг сэлгэн хадгалж буй аж ахуйн нэгжийн улсын нөөцийн шатахууны сэлгэн хадгалалтын байдалд тухай бүр хяналт тавьж, "Газрын тосны бүтээгдэхүүний улсын нөөц бүрдүүлэх журам”-ын дагуу улсын нөөцийн шатахууныг мэдээ тайланг сар бүр хүлээн авч, нэгдсэн тайланг нийт 6 удаа гаргасан.<br>Хүрсэн түвшин: 12 | |
| 1.8. | Газрын тосны бүтээгдэхүүнд чанарын хяналтын шинжилгээ хийнэ. | Үйл ажиллагааны зардлаар | Хууль журамд заасан хугацаанд шийдвэрлэсэн хүсэлтийн хувь | 100% | 100% | 1. Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн 134 дүгээр тогтоолын дагуу батлагдсан “Газрын тосны бүтээгдэхүүн импортлох, үйлдвэрлэх, бөөний болон жижиглэнгийн худалдаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд урьдчилан сэргийлэх шалгалт, хяналт хийх ажлын төлөвлөгөө”-ний хүрээнд үйл ажиллагаа явуулж буй 27 аж ахуйн нэгжийн агуулахаас нийт 178 дээжийг Газрын тосны бүтээгдэхүүний дээж авах арга MNS 0218:2008 стандартын дагуу түүвэрлэн авч шинжилгээнд | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хамруулсан.Үүнд: - Дизель түлшний -95 дээж - Автобензиний -79 дээж - Хүнд фракцийн -3 дээж - Онгоцны түлш -1 дээж Хяналт шалгалтын хүрээнд авсан бүтээгдэхүүний дээжид хийсэн шинжилгээний үр дүнгүүдийг нэгтгэн, сорилтын тайланг тус бүр 2% үйлдэн баталгаажуулсан. | |
| 1.8.1 | Евро-5 стандартад нийцсэн чанарын шаардлага хангасан шатахуунд чанарын хяналтын шинжилгээ хийх | Үйл ажиллагаа ны зардлаар | Хууль журамд заасан хугацаанд шийдвэрлэсэн хүсэлтийн хувь | 100% | Эхний хагас жилд: 100% Жилийн эцэст: 100% | Монгол улсын засгийн газрын 2024 оны 10 сарын 23 ны өдрийн дугаар 134 дүгээр тогтоол “Газрын тосны бүтээгдэхүүн импортлох, үйлдвэрлэх, бөөний болон жижиглэнгийн худалдаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд урьдчилан сэргийлэх шалгалт хянах ажлын төлөвлөгөө”-ний дагуу үйл ажиллагаа явуулж буй 27 аж ахуйн нэгжийн агуулахаас дизель түлшний - 95, автобензиний -79, хүнд фракцийн-3, онгоцны түлш-1 Нийт 178 дээжийг авч шинжилгээнд хамруулсан. 1.Шинжилгээний арга аргачлал: "Сорилтын болон шалгалт тохируулгын лабораторид тавигдах шаардлага MNS17025:2018" стандартын дагуу итгэмжлэлийн хүрээнд орсон үзүүлэлтээр МУ-д мөрдөгдөж буй стандарт арга аргачлалын дагуу физик, химийн шинжилгээг хийж гүйцэтгэсэн. Үүнд: -Дизель түлш. Техникийн шаардлага MNS6861:2020 стандарт, -Дизелийн түлш Евро. Техникийн шаардлага MNS 0216:2017 стандарт, -Хөдөлгүүрийн түлш. Этилжүүлээгүй бензин. Техникийн шаардлага MNS 0217:2017 стандарт 2. Боловсруулан, баталгаажуулсан сорилтын тайлангийн | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | тоо-178 3. Шинжилгээний үр дүнг хүргүүлсэн. Хяналт шалгалтын хүрээнд авсан бүтээгдэхүүний дээжид хийсэн шинжилгээний үр дүнгүүдийг нэгтгэн, сорилтын тайланг тус бүр 2% үйлдэн баталгаажуулсан.<br>Хүрсэн түвшин: 100% | |
| Хоёр. Төрийн үйлчилгээ, чанар хүртээмжийг сайжруулах зорилт, арга хэмжээ | | | | | | | |
| 2.1. | Эрдэс баялаг - Цахим шилжилт Уул уурхайн компани болон бүтээгдэхүүний үнийн мэдээ, Ашигт малтмал ашиглах үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлан болон техник, эдийн засгийн үндэслэл, ХАҮДТ-г цахимаар ирүүлэх, хүлээн авах цахим программын шинэчлэл, сайжруулалтын ажлыг зохион байгуулах, хэрэглээнд нэвтрүүлнэ. | Үйл ажиллагаа ны зардлаар | Программ туршигдаж 2026 оны төлөвлөгөөг хүлээж авсан байна. | 100% | 100% | - ГУУМС-ийн шинэчилсэн хувилбарыг Тайдер ХХК-тай хамтран танхимаар хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч 60 орчим ААН-ийн төлөөлөл оролцсон Геологи, Уул Уурхайн Мэдээллийн Систем (ГУУМС)-ийн талаар олон нийтэд сургалт хийх, танилцуулах, хэлэлцүүлэх арга хэмжээ амжилттай зохион байгуулав. - Геологи, уул уурхайн мэдээллийн системийн 2 дугаар шатны өргөтгөл, сайжруулалтыг 4 үе шаттайгаар хүлээн авч байгаа бөгөөд 4 дэх шатны ажлыг ХБНГУ-ЫН Геошинжлэх ухаан, байгалийн нөөцийн холбооны хүрээлэн (BGR)-ийн Эрдэс баялгийн тогтвортой удирдлагын зөвлөх үйлчилгээ төслийн хаалтын ажиллагааны үед хүлээн авсан. | 100% |
| 2.1.1 | Геологи, уул уурхайн мэдээллийн системийн 2 дугаар шатны өргөтгөл, сайжруулалтыг үргэлжлүүлэн уул уурхайн нэгдсэн сан үүсгэх, хөтлөх ажлыг зохион байгуулах, хэрэглээнд нэвтрүүлэх, | ХБНГУ-ын Геошинжл эх ухаан, байгалийн нөөцийн холбооны хүрээлэн (BGR)-гээс хэрэгжүүл ж буй | 1.Нэгдсэн сан үүсгэсэн эсэх 2.Хэрэглээнд нэвтрүүлсэн эсэх 3.Сургалт зохион байгуулсан эсэх | 1.Тийм 2.Тийм 3.Тийм | Эхний хагас жилд: 1.Тийм 2.Тийм 3.Тийм Жилийн эцэст: 1.Тийм 2.Тийм 3.Тийм | - 2025.03.18-ны өдөр ГУУМС-ийн шинэчилсэн хувилбарыг Тайдер ХХК-тай хамтран танхимаар хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч 60 орчим ААН-ийн төлөөлөл оролцсон Геологи, Уул Уурхайн Мэдээллийн Систем (ГУУМС)-ийн талаар олон нийтэд сургалт хийх, танилцуулах, хэлэлцүүлэх арга хэмжээ амжилттай зохион байгуулав. - Геологи, | 90% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | сургалт зохион байгуулах | Эрдэс баялгийн тогтвортой удирдлагын зөвлөх үйлчилгээ төсөл | | | | уул уурхайн мэдээллийн системийн 2 дугаар шатны өргөтгөл, сайжруулалтыг 4 үе шаттайгаар хүлээн авч байгаа бөгөөд 4 дэх шатны ажлыг 2025.03.20-ны өдөр ХБНГУ-ЫН Геошинжлэх ухаан, байгалийн нөөцийн холбооны хүрээлэн (BGR)-ийн Эрдэс баялгийн тогтвортой удирдлагын зөвлөх үйлчилгээ төслийн хаалтын ажиллагааны үед хүлээн авлаа. - 2026 оны Уулын ажлын төлөвлөгөө авах бэлтгэл ажлын хүрээнд ТЭЗҮ-ийн хэсгийн маягтыг боловсруулж дууссан бөгөөд ААН-ээс мэдээллийг авч ажиллаж байна.<br>Хүрсэн түвшин: 1.Тийм 2.Тийм 3.Тийм | |
| 2.1.2 | Гадаадын болон дотоодын хөрөнгө оруулагчдыг мэдээллээр хангах Уул уурхайн хөрөнгө оруулалтын гарын авлага “Mining investment Guidebook 2025”-ыг гаргах | Үйл ажиллагааны зардлаар | 1.Мэдээллийг нэгтгэн боловсруулсан эсэх 2.Гарын авлага гаргах эсэх 3.Цахим хуудас байршуулсан эсэх | 1. Үгүй 2. Үгүй 3. Үгүй | Эхний хагас жилд: 1.Тийм 2.- 3. - Жилийн эцэст: 1.Тийм 2.Тийм 3.Тийм | 1. Хөрөнгө оруулалтын гарын авлагад оруулах Монгол улсын уул уурхайн салбарын олборлолт, үйлдвэрлэл, экспортын мэдээллийг шинэчилж, хөрөнгө оруулалт шаардлагатай төслүүдийн мэдээллийг нэгтгэн боловсруулж Аж үйлдвэр, эрдэс баялгийн яаманд хүргүүлсэн. 2. Уул уурхайн салбарын хөрөнгө оруулалтын гарын авлага MINERALS AND MINING INVESTMENT GUIDE 2025 нэртэйгээр гарсан. 3. Гарын авлага брошур хэлбэрээр 2025 оны 3 дугаар сард Канад улсад зохион байгуулагдсан PDAC-ийн чуулга уулзалтад тараагдсан.<br>Хүрсэн түвшин: 1.Тийм 2.Тийм 3.Тийм | 100% |
| 2.1.3 | Уул уурхайн салбарын татварын хууль эрх зүйн орчны шинэчлэлийг судалж татварын ачааллын судалгааг | Үйл ажиллагааны зардлаар | Судалгаа хийсэн эсэх | Тийм | Эхний хагас жилд: - Жилийн эцэст: Тийм | Монгол улсын уул уурхайн салбарын татварын эрх зүйн орчны өнөөгийн байдал, түүний өөрчлөлт, шинэчлэлтийг судалж, татварын ачааллын тооцооллыг 2016-2024 оны уулын ажлын албажсан | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | голлох ашигт малтмал, татварын төрлөөр ангилан шинэчлэн тооцоолж, АҮЭБЯ-нд хүргүүлэх | | | | | тайлангийн хүрээнд бүх төрлийн ашигт малтмал, татварын төрлөөр ангилан шинэчилж "Монгол улсын уул уурхайн салбарын татварын хууль эрх зүйн орчин ба татварын ачааллын судалгаа"-г хийж, судалгааны ажлын тайланг Аж үйлдвэр, эрдэс баялгийн яаманд хүргүүлсэн.<br>Хүрсэн түвшин: Тийм | |
| Гурав. Хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ | | | | | | | |
| 3.1. | Ашигт малтмалын хайгуулын ажлын үр өгөөжийг дээшлүүлж, эрдэс баялгийн нөөцийг өсгөнө. | Үйл ажиллагааны зардлаар | Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлд ирүүлсэн хүсэлтийн шийдвэрлэлтийн хувь | 100% | 100% | Аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн хайгуулын ажлын үр дүнгийн тайланд шинжээч томилуулах 102, хайгуулын ажлын үр дүнгийн тайланд хяналтын хуудас авах 90, ЭБМЗ-ийн хурлаар тайлан хэлэлцүүлэх 95, лавлагаа, мэдээлэл хүссэн 22, УГА-ны нөөц бүртгэсэн тушаал хүргүүлэх тухай 27 нийт 336 албан бичигт хариу өгч шийдвэрлэсэн. Нийт 95 хайгуулын ажлын үр дүнгийн тайлангийн хяналтын хуудсыг хянаж шийдвэрлэсэн байна. | 100% |
| 3.1.1 | Хувийн хөрөнгөөр гүйцэтгэсэн шаардлага хангасан ашигт малтмалын хайгуулын ажлын үр дүнгийн тайлан, нөөцийн тодотгол тайланг хүлээн авч хянах, Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлэн шийдвэрлэх. Шийдвэрлэсэн тайлангаас нөөцийг ашигт малтмалын | Үйл ажиллагааны зардлаар | Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлд ирүүлсэн хүсэлтийн шийдвэрлэлтийн хувь | 100% | Эхний хагас жилд: 100%<br>Жилийн эцэст: 100% | Аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн хайгуулын ажлын үр дүнгийн тайланд шинжээч томилуулах 102, хайгуулын ажлын үр дүнгийн тайланд хяналтын хуудас авах 90, ЭБМЗ-ийн хурлаар тайлан хэлэлцүүлэх 95, лавлагаа, мэдээлэл хүссэн 22, УГА-ны нөөц бүртгэсэн тушаал хүргүүлэх тухай 27 нийт 336 албан бичигт хариу өгч шийдвэрлэсэн. Нийт 95 хайгуулын ажлын үр дүнгийн тайлангийн хяналтын хуудсыг хянаж шийдвэрлэсэн байна.<br>Хүрсэн түвшин: 100% | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | төрлөөр бүртгэн ажлын хэрэгцээний мэдээллийн санг хөтлөх | | | | | | |
| 3.1.2 | Ашигт малтмалын хайгуулын ажлын жилийн тайланг цахимаар хүлээн авах, төлөвлөгөөг хянах, шаардлага хангасан төлөвлөгөөг хүлээн авах, мэдээллийн нэгдсэн санг нэмэлт мэдээллээр баяжуулах | Үйл ажиллагаа ны зардлаар | Цахим системд хуулийн хугацаанд ААН-ээс ирүүлсэн төлөвлөгөө, тайлангийн тоогоор хянасан байна. | Төлөвлөгө ө 1261, тайлан 1048 хянасан. | Эхний хагас жилд: Төлөвлөгөө 500, тайлан 400 хянасан байна. Жилийн эцэст: Төлөвлөгөө 1160, тайлан 940 хянасан байна. | Ашигт малтмалын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1.1 дэх хэсэгт заасны дагуу 2025 оны жилийн эцсийн байдлаар Ашигт малтмалын хайгуулын хэлтэст ирүүлсэн 2025 оны хайгуулын ажлын төлөвлөгөө нийт 1294 ирснээс 1294 төлөвлөгөө хянасан байна. Үүнд: Баталгаажсан-1144 Засварт буцсан-73 Илгээсэн-11 (дахин хянагдах шатанд) Татгалзсан-66 Ашигт малтмалын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1.2 дахь хэсэгт заасны дагуу 2025 оны жилийн эцсийн байдлаар Ашигт малтмалын хайгуулын хэлтэст ирүүлсэн 2024 оны тайлан нийт 1098 ирснээс 1098 тайлан хянасан байна. Үүнд: Баталгаажсан-587 Засварт буцсан-336 Илгээсэн-174 (дахин хянагдах шатанд) Татгалзсан-1<br>Хүрсэн түвшин: Төлөвлөгөө 1294, тайлан 1098 хянасан байна. | 100% |
| 3.2. | Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг татах, Эрдэс баялгийн нөөцийг нэмэгдүүлнэ. | үйл ажиллагаа ны зардлаар | 1. Ирүүлсэн дээжийн шийдвэрлэлт хувиар 2. Тойм судалгаа хийхээр ирүүлсэн хүсэлтийн шийдвэрлэлт хувиар | 1. 100% 2. 100% | 1. 100% 2. 100% | 1. Аж ахуй нэгжээс ирүүлсэн хүсэлтийн дагуу Улсын хилээр нэвтрүүлэх 24 дээжийн тодорхойлолтыг гаргаж албан бичгээр хариуг хүргүүлсэн. 2. Аж ахуй нэгжээс ирүүлсэн хүсэлтийн дагуу Тойм судалгаа хийхээр 1 хүсэлт ирүүлснийг бүртгэж, албан бичгээр хариуг хүргүүлсэн. | 70% |
| 3.2.1 | Эрдэс баялгийн нөөцийг нэмэгдүүлэх замаар ашигт малтмалын хайгуулын ажилд хувийн хэвшлийн | Үйл ажиллагаа ны зардлаар | 1. Ирүүлсэн дээжийн шийдвэрлэлт хувиар 2. Тойм судалгаа хийхээр | 1. 100% 2. 100% | Эхний хагас жилд: 1. 100% 2. 100% Жилийн | 1. Аж ахуй нэгжээс ирүүлсэн хүсэлтийн дагуу Улсын хилээр нэвтрүүлэх 24 дээжийн тодорхойлолтыг гаргаж албан бичгээр хариуг хүргүүлсэн. 2. Аж ахуй нэгжээс ирүүлсэн хүсэлтийн дагуу Тойм | 70% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх | | ирүүлсэн хүсэлтийн шийдвэрлэлт хувиар | | эцэст: 1. 100% 2. 100% | судалгаа хийхээр 1 хүсэлт ирүүлснийг бүртгэж, албан бичгээр хариуг хүргүүлсэн.<br>Хүрсэн түвшин: 1. 100% 2. 100% | |
| 3.3. | Ашигт малтмалын тухай хуулийг хэрэгжүүлж ажиллана. | Үйл ажиллагааны зардлаар | Хэрэгжилт хангагдсан эсэх | Тийм | Тийм | 1. Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчид болон баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагаа эрхлэгч аж ахуйн нэгжүүдээс 2025 оны 543 уулын ажлын төлөвлөгөөг цахим хэлбэрээр хүлээн авч танилцсан. Үүнээс: • Албажсан – 477 • Албажаагүй – 54 • Татгалзсан – 12 2. Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчид болон баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагаа эрхлэгч аж ахуйн нэгжүүдээс 2024 оны 307 уулын ажлын тайланг хүлээн авч танилцсан. Үүнээс: • Албажсан – 130 • Албажаагүй – 177 3. ЭБМЗ-ийн ашигт малтмалын орд ашиглах техник, эдийн засгийн үндэслэл хэлэлцэх салбар зөвлөлийн 25, өргөтгөсөн 3 нийт 28 хуралдаанаар 252 төслийг хэлэлцэж хүлээн авсан - 90, засвартай хүлээн авсан - 130, буцаасан-13, хойшлуулсан-19 тус тус байна. | 93.3% |
| 3.3.1 | Ашигт малтмалын тухай хуулийн 11.1.8.-д заасан уул уурхайн үйлдвэрлэлд ашиглагдаж байгаа газар доор уусган баяжуулах техник технологийн судалгаа хийж, үнэлэлт, дүгнэлт өгөх, төслийн дэд бүтцийн боломжийг | Үйл ажиллагааны зардлаар | 1.Судалгаа хийсэн эсэх 2.Үнэлэлт өгсөн эсэх | 1.Тийм 2.Тийм | Эхний хагас жилд: 1.Тийм 2.Тийм Жилийн эцэст: 1.Тийм 2.Тийм | 2025 оны жилийн эцсийн байдлаар 2016-2024 онуудад ашиглалтын үйл ажиллагаа явуулж уулын ажлын тайлан ирүүлсэн 1676 уурхайн олборлолтын болон баяжуулалтын тоног төхөөрөмжүүдийн мэдээллийг авч нэгтгэсэн ба техник, технологийн түвшний үнэлгээ хийхэд шаардагдах суурь мэдээллийг бэлтгэн шинээр мэдээллийн санд хадгалав. | 90% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | судлах, дэмжлэг үзүүлэн ажиллах | | | | | Хүрсэн түвшин: 1.Тийм 2.Тийм | |
| 3.3.2 | Ашигт малтмалын тухай хуулийн 11.1.9 дэх заалтын дагуу хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах талаар судалгаа хийж, үнэлэлт өгч, санал, дүгнэлт гаргах, АҮЭБЯ-нд хүргүүлэх | Үйл ажиллагаа ны зардлаар | 1.Судалгаа хийсэн эсэх 2.Үнэлэлт өгсөн эсэх 3.Санал, дүгнэлт гаргасан эсэх | 1.Тийм 2.Тийм 3.Тийм | Эхний хагас жилд: - Жилийн эцэст: 1.Тийм 2.Тийм 3.Тийм | 1. 2025 оны судалгааны асуулгыг Геологи, уул уурхайн мэдээллийн шинэчилсэн системд байршуулж, 864 аж ахуйн нэгжийг судалгаанд хамруулж, асуулгын үр дүнг нэгтгэж судалгааг хийсэн. 2. Судалгааны асуулгын үр дүнд шинжилгээ хийж хөрөнгө оруулалтын орчны талаар үнэлэлт өгсөн. 3. Судалгааны асуулгын үр дүн, үнэлэлтэд тулгуурлан дүгнэлт гарган, сайжруулах саналыг боловсруулсан. Судалгааны үр дүн, үнэлэлт, санал, дүгнэлтийг нэгтгэн “Монгол улсын уул уурхайн салбарын хөрөнгө оруулалтын орчны судалгаа"-г хийж, судалгааны ажлын тайланг Аж үйлдвэр, эрдэс баялгийн яаманд хүргүүлсэн.<br>Хүрсэн түвшин: 1.Тийм 2.Тийм 3.Тийм | 100% |
| 3.3.3 | Ашигт малтмалын тухай хуулийн 11.1.10-т заасны дагуу уул уурхайн үйлдвэрлэлээс улс орны эдийн засагт үзүүлж байгаа нөлөөллийг үнэлэх судалгааг хамтран гүйцэтгэх тухай саналыг санхүүжүүлэгч байгууллагад хүргүүлэх. | Үйл ажиллагаа ны зардлаар | Санал хүргүүлсэн эсэх | Тийм | Эхний хагас жилд: - Жилийн эцэст: Тийм | 1. Монгол Улсын эдийн засаг, нийгмийн 2026 онд хөгжүүлэх үндсэн чиглэл болон Монгол Улсын нэгдсэн төсвийн мэдэгдэл 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төслийг боловсруулахад зориулж Уул уурхайн эрдэс, түүхий эд, голлох ашигт малтмалын 2025-2028 он хүртэлх үнийн төсөөллийн талаар судалгааг хийж бэлтгэн, уул уурхайн салбарын тооцоо, төсөөлөл, шаардлагатай тоон мэдээллийг Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газарт хүргүүлсэн. 2. Ашигт малтмалын үнэ ханшийн 2024 оны 12-р сар, 2025 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | оны 1-11 дүгээр саруудын мэдээллийг судалж 12 удаа нэгтгэн гаргаж, АМГТГ-ын сар бүрийн Статистик мэдээний цахим хуудаст байршуулсан. 3. Нүүрсний уурхайнуудын олборлолт, экспортын мэдээ, ашигт малтмалын үнэ ханшийн мэдээллийг сар бүр нэгтгэн боловсруулж Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд хүргүүлсэн. Хүрсэн түвшин: Тийм | |
| 3.3.4 | Ашигт малтмалын хайгуул, олборлолт эрхэлдэг аж ахуйн нэгжээс улсын төсөвт төвлөрүүлсэн албан татвар, хураамжийн мэдээллээр тайлан гаргаж Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын засаглалыг сайжруулах ажлын албанд цахимаар хүргүүлэх, холбогдох байгууллагуудыг мэдээллээр хангах. | Үйл ажиллагааны зардлаар | 1.Тайлан гаргасан эсэх 2.Тайлан хүргүүлсэн эсэх 3.Мэдээллээр ханган ажилласан эсэх | 1.Тийм 2.Тийм 3.Тийм | Эхний хагас жилд: 1.Тийм 2.Тийм 3.Тийм Жилийн эцэст: - | Ашигт малтмалын хайгуул, олборлолт эрхэлдэг аж ахуйн нэгжээс улсын төсөвт төвлөрүүлсэн албан татвар, хураамжийн 2024 оны тайланг авч нэгтгэн Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын засаглалыг сайжруулах ажлын албанд хүргүүлсэн. Хүрсэн түвшин: 1.Тийм 2.Тийм 3.Тийм | 100% |
| 3.3.5 | Уулын ажлын болон баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагааны төлөвлөгөө, тайланг аж ахуйн нэгжүүдээс хүлээн авч танилцах, хайгуулын ажлын үр дүнгийн тайлангийн нөөцийн хэсэгтэй танилцах, үндсэн | Үйл ажиллагааны зардлаар | 1.Танилцсан төлөвлөгөөний тоо 2. Танилцсан тайлангийн тоо 3.Нөөцийн тайлангийн нөөцийн хэсэгтэй танилцсан эсэх 4. Санг хөтлөсөн эсэх 5. | 1.509 2.291 3.Тийм 4.Тийм 5.Тийм | Эхний хагас жилд: 1.Төлөвлөгөөний тоо 2.Тайлангийн тоо 3.Тийм 4.Тийм 5.Тийм Жилийн эцэст: | 1. Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчид болон баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагаа эрхлэгч аж ахуйн нэгжүүдээс 2025 оны 543 уулын ажлын төлөвлөгөөг хүлээн авч танилцсан. Үүнээс: • Албажсан – 477 • Албажаагүй – 54 • Татгалзсан – 12 Мөн 2025 онд үйл ажиллагаа явуулахгүй тухай 757 Х төлөвлөгөө хүлээн авсан байна. 2. Ашиглалтын тусгай зөвшөөрөл | 90% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | үзүүлэлтүүд, уул уурхайн үйлдвэрлэл, экспорт, эдийн засаг, хөрөнгө оруулалт, хүний нөөц, техник, технологи, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, байгаль орчны нөхөн сэргээлт баяжуулах үйлдвэрийн мэдээллийг санд нэгтгэх, холбогдох байгууллагуудыг мэдээллээр хангах | | Мэдээлэл хүргүүлсэн эсэх | | 1.Төлөвлөгөөний тоо 2.Тайлангийн тоо 3.Тийм 4.Тийм 5.Тийм | эзэмшигчид болон баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагаа эрхлэгч аж ахуйн нэгжүүдээс 2024 оны 307 уулын ажлын тайланг хүлээн авч танилцсан. Үүнээс: • Албажсан – 130 • Албажаагүй – 177 Мөн 2023 онд үйл ажиллагаа явуулаагүй талаар 981 Х тайлан хүлээн авсан байна. Ашигт малтмалын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.6-д заасны дагуу 2025 оны уулын ажлын төлөвлөгөө ирүүлсэн болон ирүүлээгүй аж ахуйн нэгжийн жагсаалт, 2024 оны уулын ажлын тайлан ирүүлсэн болон ирүүлээгүй аж ахуйн нэгжийн жагсаалтыг тус тус АҮЭБЯ-ны Салбарын хяналтын газарт хүргүүлсэн.<br>Хүрсэн түвшин: 1. 477 2. 130 3. Тийм 4. Тийм 5. Тийм | |
| 3.3.6 | Газрын ховор элементийн олборлолт, баяжуулалт, боловсруулалтын төслүүдийн бүтээгдэхүүн гаргалт, эдийн засгийн үр өгөөж зэрэг үзүүлэлтээр хэтийн төлөвийн судалгаа хийх, АҮЭБЯ-нд хүргүүлэх. | Үйл ажиллагааны зардлаар | Хийсэн судалгааний тоо | 0 | Эхний хагас жилд: 0 Жилийн эцэст: 1 | Олон улсын газрын ховор элементийн зах зээлийн өнөөгийн байдал, хэтийн төлөв, Монгол улсын газрын ховор элементийн хайгуул, ашиглалтын байдлыг судалж, ирээдүйд газрын ховор элементийн олборлолт, баяжуулалт, боловсруулалтын төслүүдээс гарах бүтээгдэхүүн, эдийн засгийн үр өгөөж, ажлын байр үзүүлэлтүүдийг нэгтгэн боловсруулж "Монгол улсын газрын ховор элементийн хэтийн төлөвийн судалгаа"-г хийж, судалгааны ажлын тайланг Аж үйлдвэр, эрдэс баялгийн яаманд хүргүүлсэн.<br>Хүрсэн түвшин: 1 | 90% |
| 3.3.7 | Ашигт малтмалын орд, баяжуулах үйлдвэрийг ашиглах техник, эдийн | Үйл ажиллагаа | 1.ТЭЗҮ-тэй танилцсан эсэх 2.Дүгнэлт, тушаал | 1.Тийм 2.Тийм 3. | Эхний хагас жилд: 1.Тийм 2.Тийм | ЭБМЗ-ийн ашигт малтмалын орд ашиглах техник, эдийн засгийн үндэслэл хэлэлцэх салбар зөвлөлийн 25, | 90% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | засгийн үндэслэлийг хүлээн авах, хянах, ЭБМЗ-ийн хурлаар хэлэлцүүлэх, хурлыг зохион байгуулах, оролцох, холбогдох шийдвэрийг албажуулах ажлыг зохион байгуулах, мэдээ тайлан гаргах | ны зардлаар | гаргасан эсэх 3.ЭБМЗ-ийн ТЭЗҮ-ний салбар хуралдааны тоо 4. Санг хөтөлсөн эсэх 5. Мэдээлэл хүргүүлсэн эсэх | 28 4.Тийм 5.Тийм | 3.Хуралдааны тоо 4.Тийм 5.Тийм Жилийн эцэст: 1.Тийм 2.Тийм 3.Хуралдааны тоо 4.Тийм 5.Тийм | өргөтгөсөн 3 нийт 28 хуралдаанаар 252 төслийг хэлэлцэж хүлээн авсан - 90 засвартай хүлээн авсан - 130 буцаасан-13 хойшлуулсан-19 тус тус байна. Нийт 240 техник, эдийн засгийн үндэслэлийн хурлын тэмдэглэл, 240 дүгнэлтийг боловсруулан баталгаажуулж аж ахуй нэгжид хүргүүлсэн. Техник, эдийн засгийн үндэслэлийн холбогдох мэдээллийг ирүүлсэн хүсэлтийн дагуу бэлтгэж Монгол Улсын Их Хурлын гишүүн, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам, Монгол банк, Авлигатай тэмцэх газар, Цагдаагийн ерөнхий газар зэрэг байгууллагад 5 удаа хүргүүлсэн.<br>Хүрсэн түвшин: 1.Тийм 2.Тийм 3. 28 4.Тийм 5.Тийм | |
| 3.3.8 | Ашиглалтад бэлтгэсэн уурхай, уулын үйлдвэрийг байнгын ашиглалтад хүлээн авах Улсын комиссын бүрэлдэхүүнд ажиллах, шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавих | Үйл ажиллагаа ны зардлаар | Комисст ажилласан эсэх | Тийм | Эхний хагас жилд: Тийм Жилийн эцэст: Тийм | Ашигт малтмалын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.4 дэх хэсэгт заасны дагуу үйл ажиллагаа эхлүүлэхээр бэлэн болж Улсын комисс ажиллуулахаар хүсэлт гаргасан 30 аж ахуйн нэгжийн Улсын комиссын бүрэлдэхүүнд орж ажиллан 13 удааны томилолтоор холбогдох санал дүгнэлтийг гаргаж ажилласан.<br>Хүрсэн түвшин: Тийм | 90% |
| 3.3.9 | Ашиглалтын тусгай зөвшөөрлийн хүрээнд үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийн уурхай, баяжуулах үйлдвэрүүд нь тухайн жилийн уулын ажлын төлөвлөгөөний дагуу явагдаж буй | Үйл ажиллагаа ны зардлаар | Томилолтоор ажилласан эсэх | Тийм | Эхний хагас жилд: Тийм Жилийн эцэст: Тийм | 2025 онд нийт 18 удаагийн албан томилолтоор ажилласан. Төлөвлөгөөт - 1 Төлөвлөгөөт бус - 4 Улсын комисс - 13<br>Хүрсэн түвшин: Тийм | 90% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | эсэхэд хамтран газар дээр нь танилцаж, санал, зөвлөгөө өгөх | | | | | | |
| 3.4. | Газрын хэвлийн тухай хуулийг хэрэгжүүлж ажиллана. | Үйл ажиллагаа ны зардлаар | Хэрэгжилт хангагдсан эсэх | Тийм | Тийм | - Газрын хэвлийн тухай хуулийн 32, 45 дугаар зүйлд заасны дагуу 2023 оны 247 уулын ажлын тайлангийн нөөцийн хөдөлгөөний тоо бүртгэлийг хөтөлж, ҮГА-ны Геологийн баримтын төв архивд нөөцийн хөдөлгөөнийг хүргүүлсэн. | 90% |
| 3.4.1 | Газрын хэвлийн тухай хуулийн 32, 45 дугаар зүйлд заасны дагуу 2024 онд олборлолт явуулсан ордуудын үйл ажиллагааны тайлантай холбогдох заавар, журмын дагуу танилцаж ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайнуудад ногдох ашигт малтмалын нөөцийн хөдөлгөөний тоо бүртгэлийг хөтлөх нөөцийн хөдөлгөөнийг ҮГА-д хүргүүлэх | Үйл ажиллагаа ны зардлаар | 1.Танилцсан тайлангийн тоо 2.Хүргүүлсэн эсэх | 1. 194 2.Тийм | Эхний хагас жилд: 1.Тайлангийн тоо 2.Тийм Жилийн эцэст: - | - Газрын хэвлийн тухай хуулийн 32, 45 дугаар зүйлд заасны дагуу 2023 оны 247 уулын ажлын тайлангийн нөөцийн хөдөлгөөний тоо бүртгэлийг хөтөлж, ҮГА-ны Геологийн баримтын төв архивд нөөцийн хөдөлгөөнийг хүргүүлсэн. - Газрын хэвлийн тухай хуулийн 32, 45 дугаар зүйлд заасны дагуу 2024 оны 130 уулын ажлын тайлангийн нөөцийн хөдөлгөөнийг хийсэн.<br>Хүрсэн түвшин: 1.130 2.Тийм | 90% |
| 3.5. | Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, олборлох, ашиглахыг хориглох тухай хуулийг хэрэгжүүлж ажиллана. | Үйл ажиллагаа ны зардлаар | Хэрэгжилт хангагдсан эсэх | Тийм | Тийм | 1. Гэрээ байгуулсан 33 АТЗ-ийн талбайн 2024 оны гүйцэтгэлийн тайланг хүлээн авч мэдээллийн сан үүсгэсэн. 2. Ажлын хэсэг 5 удаа хуралдан 33 АТЗ-ийн талбайд байгуулсан гэрээний хэрэгжилттэй танилцаж, 25 ААН-ийн гэрээг сунгаж, 2 ААН-д зөвлөмж хүргүүлж, 1 ААН- ийн гэрээг шинээр байгуулж, 1 ААН хуралд ирээгүй байна. | 90% |
| 3.5.1 | Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан | Үйл ажиллагаа | 1.Хэрэгжилт хангагдсан эсэх | 1.Тийм 2.Тийм | Эхний хагас жилд: 1.Тийм | 1. АМГТГ-ын даргын 2024.12.26-ны өдрийн А/134 дугаар тушаалаар | 90% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, олборлох, ашиглахыг хориглох тухай хуулийн хэрэгжилтийг хангах, хэрэгжилттэй холбоотой мэдээллийг нэгтгэх, гэрээний үйл ажиллагаанд оролцох, холбогдох байгууллагыг мэдээллээр хангах | ны зардлаар | 2.Мэдээллийг нэгтгэсэн эсэх 3.Гэрээ дүгнэсэн эсэх 4.Мэдээллээр хангасан эсэх | 3.Тийм 4.Тийм | 2.Тийм 3.Тийм 4.Тийм Жилийн эцэст: 1.Тийм 2.Тийм 3.Тийм 4.Тийм | байгуулагдсан Усны сан бүхий газрын энгийн хамгаалалтын бүсэд олборлолт явуулж эхэлсэн тусгай зөвшөөрөл бүхий талбайд холбогдох арга хэмжээ авах, нөхөн сэргээх үйл ажиллагааны гэрээ байгуулсан аж ахуйн нэгжүүдийн гэрээ дүгнэх ажлын хэсэг байгуулж, гэрээ байгуулсан 33 АТЗ-ийн талбайн 2024 оны гүйцэтгэлийн тайланг хүлээн авч мэдээллийн сан үүсгэсэн. 2. Ажлын хэсэг 5 удаа хуралдан 33 АТЗ-ийн талбайд байгуулсан гэрээний хэрэгжилттэй танилцаж, 25 ААН-ийн гэрээг сунгаж, 2 ААН-д зөвлөмж хүргүүлж, 1 ААН- ийн гэрээг шинээр байгуулж, 1 ААН хуралд ирээгүй байна. 3. Холбогдох байгууллага, ажлын хэсэг, удирдлагуудыг тухай бүр мэдээллээр хангаж ажилласан.<br>Хүрсэн түвшин: 1.Тийм 2.Тийм 3.Тийм 4.Тийм | |
| 3.6. | Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хуулийг хэрэгжүүлж ажиллана. | Үйл ажиллагаа ны зардлаар | Хэрэгжилт хангагдсан эсэх | Тийм | Тийм | Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн асуудлаар санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий Мэргэжлийн зөвлөлийн бүрэлдэхүүнд ажиллан 2025 оны жилийн эцсийн байдлаар 6 удаагийн хуралдаанаар нийт 32 аж ахуйн нэгжид тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл импортлох, үйлдвэрлэх, тэсэлгээний ажил явуулах тусгай зөвшөөрөл олгох, сунгах болон үйлдвэр-агуулахын техник-эдийн засгийн үндэслэлд санал өгч ажилласан. | 90% |
| 3.6.1 | Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих | Үйл ажиллагаа | 1.Хэрэгжилт хангагдсан эсэх 2. Санал, дүгнэлт | 1.Тийм 2.Тийм 3. 8 | Эхний хагас жилд: 1.Тийм 2.Тийм | Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн асуудлаар санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий Мэргэжлийн | 90% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | тухай хуулийн хэрэгжилтийг хангах, тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн асуудлаар санал дүгнэлт гаргах үүрэг бүхий мэргэжлийн зөвлөлийн хуралдааныг зохион байгуулах, санал, дүгнэлт өгч ажиллах | ны зардлаар | гаргасан эсэх 3.Хуралдаанд оролцсон тоо | | 3.Хуралдаан ий тоо Жилийн эцэст: 1.Тийм 2.Тийм 3.Хуралдаан ий тоо | зөвлөлийн бүрэлдэхүүнд ажиллан 2025 оны жилийн эцсийн байдлаар 6 удаагийн хуралдаанаар нийт 32 аж ахуйн нэгжид тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл импортлох, үйлдвэрлэх, тэсэлгээний ажил явуулах тусгай зөвшөөрөл олгох, сунгах болон үйлдвэр-агуулахын техник-эдийн засгийн үндэслэлд санал өгч ажилласан.<br>Хүрсэн түвшин: 1.Тийм 2.Тийм 3. 6 | |
| 3.6.2 | Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтийн хүрээнд шаардлагатай дүрэм, журмын төсөлд санал өгөх | Үйл ажиллагаа ны зардлаар | Санал өгсөн эсэх | Тийм | Эхний хагас жилд: Тийм Жилийн эцэст: Тийм | Тэсэлгээний ажлын аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрмийн өөрчлөлтөд санал өгч, тус дүрэм Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэгдэн батлагдсан.<br>Хүрсэн түвшин: Тийм | 90% |
| 3.7. | Холбогдох байгууллагад тодорхойлолт лавлагаа өгөх | Үйл ажиллагаа ны зардлаар | Тодорхойлолт, лавлагаа өгсөн эсэх | Тийм | Тийм | Татварын ерөнхий газар болон бусад байгууллага, аж ахуйн нэгжид ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжүүдээс уулын ажлын төлөвлөгөө, тайланг ирүүлсэн талаарх нийт 139 лавлагаа, тодорхойлолтыг тухай бүр гаргаж, албан бичгээр хүргүүлсэн. “Монгол Улсын хилээр шинжилгээний дээж нэвтрүүлэхэд тодорхойлолт олгох заавар”-ын дагуу материалаа бүрдүүлэхийг зөвлөж, 150 дээжийн тодорхойлолтыг Гаалийн ерөнхий газрын харьяа газруудад хүргүүлсэн. | 90% |
| 3.7.1 | Улсын хилээр гадаргуун болон гүний усны шинжилгээ, баяжуулалт, хагас | Үйл ажиллагаа | Ирүүлсэн хүсэлтийн дагуу гаргасан | 100% (133) | Эхний хагас жилд: 100% | 2025 оны жилийн эцсийн байдлаар аж ахуйн нэгжээс цахим шуудан болон цаасаар ирүүлсэн дээжийн тодорхойлолт олгох хүсэлттэй | 90% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | үйлдвэрлэл, технологийн туршилт, шинжилгээний зориулалтаар ашигт малтмалын хүдэр, баяжмал, чулуулгийн дээж нэвтрүүлэх тухай тодорхойлолтыг журмын дагуу харьяа гаалийн хороо, газарт гаргаж өгөх | ны зардлаар | тодорхойлолт хувиар | | Жилийн эцэст: 100% | танилцаж, Ашигт малтмалын газрын даргын 2009 оны “Монгол Улсын хилээр шинжилгээний дээж нэвтрүүлэхэд тодорхойлолт олгох заавар”-ын дагуу материалаа бүрдүүлэхийг зөвлөж, 150 дээжийн тодорхойлолтыг Гаалийн ерөнхий газрын харьяа газруудад хүргүүлсэн.<br>Хүрсэн түвшин: 100% | |
| 3.8. | Цөмийн энергийн тухай хуулийн хэрэгжүүлж ажиллана. | Үйл ажиллагаа ны зардлаар | Хэрэгжилт хангагдсан эсэх | Тийм | Тийм | Цөмийн энергийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. 1. Цацраг идэвхт ашигт малтмал экспортлох тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааны журам болон Цацраг идэвхт ашигт малтмал тээвэрлэх тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааны журмын төслийг боловсруулаад Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам, Цөмийн энергийн ажлын албаны комисс болон Зам, тээврийн яаманд санал авахаар хүргүүлсэн. 2. Цөмийн энергийн комиссоос батлагдсан цацраг идэвхт ашигт малтмалтай холбоотой дүрэм, журмууд, Оросын холбооны улс, Казакстан улсын Цацраг идэвхт ашигт малтмал импортлох, экспортлох, тээвэрлэх, хаягдлыг булшлах болон цацраг идэвхт ашигт малтмал ашигласны дараа газар нөхөн сэргээх хууль тогтоомжийн судалгаа хийсэн. | 90% |
| 3.8.1 | Цацраг идэвхт ашигт малтмал импортлох, экспортлох, тээвэрлэх, хаягдлыг булшлах | Үйл ажиллагаа ны зардлаар | 1.Төсөл боловсруулсан эсэх<br>2.Судалгаа хийсэн эсэх | 1.Тийм<br>2.Тийм | Эхний хагас жилд: -<br>Жилийн эцэст: | 1. Цацраг идэвхт ашигт малтмал экспортлох тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааны журам болон Цацраг идэвхт ашигт малтмал тээвэрлэх тусгай | 90% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | болон цацраг идэвхт ашигт малтмал ашигласны дараа газар нөхөн сэргээх дүрэм, журмын төсөл боловсруулах, судалгаа хийх | | | | 1.Тийм<br>2.Тийм | зөвшөөрөл олгох үйл ажиллагааны журмын төслийг боловсруулаад Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам, Цөмийн энергийн ажлын албаны комисс болон Зам, тээврийн яаманд санал авахаар хүргүүлсэн. 2. Цөмийн энергийн комиссоос батлагдсан цацраг идэвхт ашигт малтмалтай холбоотой дүрэм, журмууд, Оросын холбооны улс, Казакстан улсын Цацраг идэвхт ашигт малтмал импортлох, экспортлох, тээвэрлэх, хаягдлыг булшлах болон цацраг идэвхт ашигт малтмал ашигласны дараа газар нөхөн сэргээх хууль тогтоомжийн судалгаа хийсэн.<br>Хүрсэн түвшин: 1.Тийм 2.Тийм | |
| 3.9. | Бичил уурхайн журмын хэрэгжилтийг хангах. | Үйл ажиллагааны зардлаар | Хэрэгжилт хангагдсан эсэх | Тийм | Тийм | Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох талбайн дүгнэлт гаргах дотоод хяналтын хуудасны мэргэжлийн шүүлт хийх ажлын хүрээнд 10 аймгийн 25 сумын нутагт орших 113 талбайн ГБТА-д байгаа давхардсан тоогоор 1145 тайлан болон уг талбайд хамаарах тусгай зөвшөөрлийн 97 тайлантай тус тус танилцаж, 103 хуудас материал канондож, 457 тайлангийн зураг скайнердаж авлаа. Эдгээ материалд үндэслэн эдийн засгийн үр ашиггүй орд, үүсмэл талбайн мэдээлэл байгаа эсэх талаар дотоод хяналтын хуудсанд тэмдэглэл үйлдэж, 499 зураг, баримт материалыг хавсаргав. | 90% |
| 3.9.1 | Бичил уурхайн журмын хэрэгжилтийг хангах, холбогдох судалгаа | Үйл ажиллагаа | Хэрэгжилт хангагдсан эсэх | Тийм | Эхний хагас жилд: Тийм | 1. Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох талбайн дүгнэлт гаргах дотоод хяналтын хуудасны мэргэжлийн | 90% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | мэдээллийг боловсруулах, АҮЭБЯ-нд хүргүүлэх | ны зардлаар | | | Жилийн эцэст: Тийм | шүүлт хийх ажлын хүрээнд 10 аймгийн 25 сумын нутагт орших 113 талбайн ГБТА-д байгаа давхардсан тоогоор 1145 тайлан болон уг талбайд хамаарах тусгай зөвшөөрлийн 97 тайлантай тус тус танилцаж, 103 хуудас материал канондож, 457 тайлангийн зураг скайнердаж авлаа. Эдгээ материалд үндэслэн эдийн засгийн үр ашиггүй орд, үүсмэл талбайн мэдээлэл байгаа эсэх талаар дотоод хяналтын хуудсанд тэмдэглэл үйлдэж, 499 зураг, баримт материалыг хавсаргав. 2. Дараах мэдээллийг хүлээн авч, санд нэгтгэв. Үүнд: - МБУНДХ-ны 2024 оны ажлын тайлан, 2025 оны ажлын төлөвлөгөө, 2025 оны хагас жилийн тайлан - Бичил уурхайн сургалтын мэдээ - Ховд аймгийн Алтан уулын эздийн холбоо ГҮТББ-тай байгуулсан Санамж бичиг, Сургалтын хөтөлбөр 3. Дараах байгууллага, ажилтанд мэдээлэл хүргүүлэн ажиллаа. Үүнд: - планетголд төсөлд бичил уурхайн дүгнэлт гарсан талбайн жагсаалт хүргүүлсэн. - "Монгол дархны уламжлал, шинэчлэл" анхдугаар чуулганд панелистаар оролцоход шаардлагатай бичил уурхайн мэргэжлийн шүүлтийн нэгтгэл, бичил уурхайн мэдээ, тайлангийн нэгтгэл, Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журмын хэрэгжилтийн талаар мэдээлэл бэлтгэсэн.<br>Хүрсэн түвшин: Тийм | |
| 3.9.2 | Бичил уурхайн зориулалтаар ашигт малтмал олборлох | Үйл ажиллагаа | Хуульд нийцүүлэн гаргасан дүгнэлтийн хувь | 100% | Эхний хагас жилд: 100% | Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох боломжтой тухай 90 талбайн дүгнэлтийн Баянхонгор-17, Хэнтий-35, | 90% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | талбайн дүгнэлт гаргаж хүргүүлэх | ны зардлаар | | | Жилийн эцэст: 100% | Сэлэнгэ-4, Төв-7, Дундговь-9, Говь-Алтай-1, Ховд-1, Булган-6, Дархан-Уул-8, Өвөрхангай-1, Дорноговь-1/ төсөл, бичил уурхайгаар ашигт малтмал олборлох боломжгүй тухай 229 талбайн дүгнэлтийн төсөл хянав. Баян-Өлгий аймгийн Толбо сумын нутаг Хашаатын ам нэртэй 4.76 гектар талбайд гаргасан дүгнэлтийг Авлигатай тэмцэх газраас албан бичгээр ирүүлсэн Баян-Өлгий аймгийн Засаг даргын тамгын газрын хяналт шалгалт хийсэн 2025 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн 1 дугаартай танилцуулгыг үндэслэн бичил уурхайгаар ашигт малтмал олборлох дүгнэлтийг цуцалж, Уул уурхайн кадастрын бүртгэлээс хассан тухай Баян-Өлгий аймгийн Засаг даргад 2025 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн 10/1340, Авлигатай тэмцэх газарт 2025-03-25-ны өдрийн 10/1373 дугаартай албан бичгээр мэдэгдсэн болно. Тайлант хугацаанд Кадастрын хэлтсийн даргын Шүүхийн шийдвэрийг биелүүлэн гаргасан 2025-01-15-ны 41, 2025-01-17-ны 121, 2025-03-12-ны 180, 2025-03-25-ны 207, 2025-03-31-ний 218, 2025-04-22-ны 263, 2025-05-12-ны 287, 2025-05-29-ны 322, 2025-07-09-ний 398, 2025-08-06-ны 437, 2025-08-14-ний 457, 2025-09-10-ны 503, 2025-09-18-ны 513, 2025-09-18-ны 512, 2025-09-18-ны 5148 2025-10-30-ны 576, 2025-11-17-ны 592 дугаар нийт 24 шийдвэрийн төслийг хянасан.<br>Хүрсэн түвшин: 100% | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3.10. | Газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуулын ажлыг зохион байгуулж дэмжих | Үйл ажиллагаа ны зардал. | Газрын тосны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.6 дахь хэсэгт заасны дагуу эрх олгосон тохиолдолд бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулсан хувиар | 100% | 100% | Засгийн газрын 2024 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн 166 дугаар тогтоолоор Борзон VII талбайд Петро Матад Энержи Лимитед компанитай БХГ байгуулах эрхийг Ашигт малтмал, газрын тосны газарт олгосны дагуу Ашигт малтмал, газрын тосны газар болон Петро Матад Энержи Лимитед компанийн хооронд хайгуул, ашиглалтын үйл ажиллагаа эрхлэх БХГ-г 2025 оны 01 дүгээр сарын 16-ны өдөр байгуулсан. 2.Засгийн газрын 2024 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн 167 дугаар тогтоолоор Ачит XXXVII талбайд Тэмүүжин металс ХХК-тай БХГ байгуулах эрхийг Ашигт малтмал, газрын тосны газарт олгосны дагуу Ашигт малтмал, газрын тосны газар болон Тэмүүжин металс ХХК-ийн хооронд нүүрсний давхаргын метан хийн хайгуул, ашиглалтын үйл ажиллагаа эрхлэх БХГ-г 2025 оны 01 дүгээр сарын 06-ны өдөр байгуулсан. Газрын тосны тухай хууль, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль, Гаалийн тариф, гаалийн татварын тухай хууль, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль, бусад хууль тогтоомж дүрэм, журамд нийцүүлэн гааль, татвар, орон нутгийн удирдлагын зэрэг байгууллагууд руу хандан гэрээлэгчдийн газрын тосны хайгуулын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж хамтран ажиллах албан хүсэлтүүдийг хүргүүлсэн. Үүнд: Гаалийн ерөнхий газарт: Монголын алт /МАК/ ХХК /хилээр оруулж ирэх цооногийн туршилтын тоног төхөөрөмж 507 горим/, | 92.5% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Смарт ойл ХХК /хилээр оруулж ирэх өрөмдлөгийн тоног төхөөрөмж 507 горим/, /хилээр оруулж ирэх өрмийн яндан хоолой 403 горим/, Метан газ ресурс ХХК /хилээр оруулж ирэх хэвтээ цооногт зориулсан тусгай цемент/, /хилээр оруулж ирэх хэвтээ цооногийн яндан, бэхэлгээний төхөөрөмж/, /хилээр оруулж ирэх хөндлөн өрөмдлөгийн дагалдах хэрэгсэл/, /хилээр оруулж ирэх туршилтын олборлолтын төхөөрөмж/, Тэлмэн ресурс ХХК / хилээр оруулж ирэх туршилтын олборлолтын дагалдах хэрэгсэл/, Гадаадын иргэн, харьяатын газарт: Метан газ ресурс ХХК /тусгай тоног төхөөрөмжийн мэргэжилтнүүд орж ирэх виз - түр хугацаагаар ажиллах зөвшөөрөл/, Гэрээлэгчид: дэмжлэг, зөвлөгөө /Тэмүүжин металс ХХК/. | |
| 3.10.1 | Газрын тос, уламжлалт бус газрын тосны хайгуулын талбайд болон эрлээс хайгуулд шилжиж байгаа талбайд бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулах. | Үйл ажиллагаа ны зардлаар | Газрын тосны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.6 дахь хэсэгт заасны дагуу эрх олгосон тохиолдолд бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулсан хувиар | 100% | Эхний хагас жилд: 100% Жилийн эцэст: 100% | 1.Засгийн газрын 2024 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн 166 дугаар тогтоолоор Борзон VII талбайд Петро Матад Энержи Лимитед компанитай БХГ байгуулах эрхийг Ашигт малтмал, газрын тосны газарт олгосны дагуу Ашигт малтмал, газрын тосны газар болон Петро Матад Энержи Лимитед компанийн хооронд хайгуул, ашиглалтын үйл ажиллагаа эрхлэх БХГ-г 2025 оны 01 дүгээр сарын 16-ны өдөр байгуулсан. 2.Засгийн газрын 2024 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн 167 дугаар тогтоолоор Ачит XXXVII талбайд Тэмүүжин металс ХХК-тай БХГ байгуулах эрхийг Ашигт малтмал, газрын тосны газарт олгосны дагуу Ашигт малтмал, газрын тосны газар болон Тэмүүжин металс ХХК-ийн | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хооронд нүүрсний давхаргын метан хийн хайгуул, ашиглалтын үйл ажиллагаа эрхлэх БХГ-г 2025 оны 01 дүгээр сарын 06-ны өдөр байгуулсан. 3. Эрлийн гэрээт Коммон макс ХХК-аас 2025 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн 28/25 дугаар албан бичгээр ирүүлсэн шатдаг занарын хайгуулын БХГ байгуулах хүсэлтийг ГСШЖ-ын дагуу хянан үзэх, БХГ-ний үндсэн нөхцөл болон бусад асуудлаар хэлэлцээ хийх тухай АМГТГ-ын даргын 2025 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн А/223 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг ажиллаж байна. Ажлын хэсэг захиалгын материалыг хянан үзээд 2025 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн Захиалгын материал бүрдүүлж ирүүлэх тухай 7/5946 дугаар албан бичгийг тус компанид хүргүүлэв.<br>Хүрсэн түвшин: 100% | |
| 3.10.2 | Газрын тос, уламжлалт бус газрын тосны эрлийн ажил хийх хүсэлт хүлээн авч судалж, санал дүгнэлт гаргах, холбогдох хууль дүрэм журмын шаардлага хангасан хуулийн этгээдтэй эрлийн гэрээ байгуулах | Үйл ажиллагааны зардлаар | Эрлийн ажил хийхээр ирүүлсэн хүсэлтийг судалж, шаардлага хангасан эрлийн гэрээ байгуулсан хувиар | 100% | Эхний хагас жилд: 100%<br>Жилийн эцэст: 100% | Цоож майнинг ХХК-аас 2024 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн 25/01 дугаартай албан бичгээр нүүрсний давхаргын метан хийн эрлийн гэрээ байгуулах хүсэлтийг ирүүлсэн. Газрын тосны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.3.-т "Төрийн захиргааны байгууллага энэ хуулийн 16.1-д заасан эрэл хийх хүсэлтийг хүлээн авснаас хойш 30 хоногийн хугацаанд судалж, шийдвэр гаргана." заасныг үндэслэн хяналтын хуудас нээн эрлийн талбайн давхцал, компанийн мэргэжлийн чадавх, эрлийн ажлын аргачлал, төлөвлөгөө, төсөв болон байгаль орчны ажил захиалагчийн эрхзүйн баримт бичиг, | 90% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хөрөнгө, оруулалт, санхүүгийн чадварын талаар тус тус дүгнэлтийг гаргасан. Гаргасан санал, дүгнэлтийг үндэслэн Ашигт малтмал, газрын тосны газар болон Цоож майнинг ХХК-ийн хооронд Дорноговь аймгийн Өргөн, Сайншанд, Улаанбадрах, Хөвсгөл, Эрдэнэ сумдын нутгийн хэсэгчлэн хамрах талбайд 2025 оны 03 дугаар сарын 10-ны өдөр 3 жилийн хугацаатай эрлийн ажил гүйцэтгэх гэрээ байгуулсан.<br>Хүрсэн түвшин: 100% | |
| 3.10. 3 | Газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуулын ажлын жилийн төлөвлөгөө, төсвийг батлах, түүний гүйцэтгэлд хяналт тавих. | Үйл ажиллагаа ны зардлаар | Иргүүлсэн эрэл, хайгуулын төлөвлөгөө, төсвийг зааварт нийцүүлэн баталсан эсэх | Тийм | Эхний хагас жилд: Тийм Жилийн эцэст: Тийм | 1.Эрлийн ажлын төлөвлөгөө, төсөв - “Си эйч би ти ти” ХХК-ийн Асгат, -“Си эйч би ти ти” ХХК Эрдэнэцагаан -“Баруун наран газ” ХХК, -"Ууганбулаг", -"Цоож майнинг" ХХК, - "Ийстрен газ эксплорейшн" - Бөмбөлөгт Эрдэс ХХК - Оргих бүрд хишиг ХХК нийт 7 эрлийн гэрээт компанийн 8 эрлийн ажлын төлөвлөгөө, төсвийг батлуулсан. (Хавсралтаар эрлийн ажлын төлөвлөгөө, төсвийн нэгтгэлийг хавсаргав. 2. Хайгуулын ажлын төлөвлөгөө, төсөв - Монголын Алт” /МАК/ ХХК 2025.02.18, - “Тахь ресурс” ХХК 2025.02.27, - “Метан газ ресурс” ХХК 2025.02.28, - "Монголиа Фойсон Энержи" ХХК 2025.03.14, - "Юу Жи Эс" ХХК 2025.03.24, “Тэлмэн Ресурс” ХХК 2025.03.28, - "Баян петролиум" ХХК 2025.03.28, - “Жи Өү Эйч” ХХК 2025.03.28, - “Смарт ойл Монголиа” ХХК 2025.03.31, - “Түмэн ойл” ХХК 2025.03.31, - "Макс Ойл" ХХК 2025.03.31, - "Петроматад энержи лимитед" компани 2025.05.07-ны өдрүүдэд нийт | 90% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 12 компанийн 14 төлөвлөгөө, төсвийг тус тус батлуулсан. (Хавсралтаар хайгуулын ажлын төлөвлөгөө, төсвийн нэгтгэлийг хавсаргав. Холбогдох мэдээллийг 2025.04.29-ний 3/2034 албан бичгээр АҮЭБЯ-нд хүргүүлэв. 3. Төлөвлөгөө, төсөв батлуулаагүй гэрээлэгчдийн талаарх - Тайлбар: 1"Шунхлай Энержи" ХХК-тай 2025.01.31-ний өдөр хийсэн ЖАУ-аар шүүхийн маргаан дуустал БХГ-ний биелэлтийг ГТТХ-ийн 13 дугаар зүйлийн 13.1-д заасны дагуу дүгнэх ажлыг түр хойшлуулах санал гаргаж энэ тухай АҮЭБЯ-нд хүргүүлэхээр шийдвэрлэсэн. - Тайлбар: 2. "Зон Хэн Юу Тиан" ХХК-д 2025 оны хайгуулын ажлын төлөвлөгөөг ирүүлэх талаар 2024.12.10-ны өдрийн 3/5157, 2025.03.19-ний өдрийн 3/1268 а/б-ийг тус тус хүргүүлсэн. Төлөвлөгөө ирүүлээгүй. - Тайлбар:3. "Чайна голденсий петролиум эксплорэйшн корпорэйшн" ХХК-д 2025 оны хайгуулын ажлын төлөвлөгөөг ирүүлэх талаар манай газраас 2024.12.10-ны өдрийн 3/5157, 2025.03.19-ний өдрийн 3/1268 албан бичгүүдийг тус тус хүргүүлсэн. 2025.03.26-ны өдөр хийсэн уулзалтаар төлбөр урамшууллуудыг төлж, үүссэн зөрчлүүдийг арилгасны дараа төлөвлөгөө, төсөв ирүүлэх болон ЖАУ-ыг дахин хийх үүрэг өгсөн боловч үүссэн зөрчлийг арилгаагүй.<br>Хүрсэн түвшин: Тийм | |
| 3.10.4 | Эрэл, хайгуулын талбайд гүйцэтгэсэн газрын тос, уламжлалт | Үйл ажиллагаа | Журмын шаардлагад | 100% | Эхний хагас жилд: 100% | 1. Эрлийн ажил гүйцэтгэх гэрээт: Оргихбүрд хишиг ХХК, Уганбулаг ХХК, Си Эйч би ти ти ХХК /Эрдэнэцагаан, | 90% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | бус газрын тосны геологи, геофизик, гидрогеологи, геохими, өрөмдлөг, хайгуул, ашиглалттай холбогдсон үйл ажиллагааны анхдагч мэдээлэл, тайлан, материалыг хянаж хүлээн авах. | ны зардлаар. | нийцсэн тайланг хүлээн авсан хувиар | | Жилийн эцэст: 100% | Асгат/, Хэнсүл ХХК, Ийстрен газ эксплорэйшн ХХК, Баруунnаран газ ХХК, Хэнсүл ХХК Бөмбөлөгт Эрдэс ХХК-уудаас ирүүлсэн холбогдох 14 тайланг (Тайлангийн бүртгэлийг хавсаргав) 2. БХГ-т Тахь ресурс ХХК-ийн Богд IV, Онги V, Жи Өү Эйч ХХК -ийн Номгон IX, Метангаз ресурс ХХК-ийн Тавантолгой XXXIII, Монголын Алт (МАК) ХХК-ийн Төхөм X урд , Тэлмэн ресурс ХХК -ийн Гурвантэс XXXV талбайн 2024 оны жилийн ажлын тайлангууд болон дээрх гэрээт талбайнуудад хийгдсэн цооногийн тайлан, 2 хэмжээст чичирхийллийн судалгаа зэрэг нийт 31 тайлан ирүүлснээс заавар шаардлагад нийцсэн 30 тайланг хүлээн авч, 1 тайланг засварт буцаасан. 3. Эрлийн гэрээт Коммон макс ХХК, Жейд газ Монголиа ХХК-ийн 2, Хэнсүл констракшн ХХК-ийн эрлийг гэрээт талбайд хийгдсэн эрлийн ажлын үр дүнгийн тайланг Газрын тосны техникийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж тайлангуудыг хүлээн авах тухай шийдвэр гаргуулсан.<br>Хүрсэн түвшин: 100% | |
| 3.10.5 | Эрлийн гэрээ болон Бүтээгдэхүүн хуваах гэрээний хэрэгжилтийг хангуулах, батлагдсан төлөвлөгөөт ажлын гүйцэтгэлд газар дээр нь хяналт тавих. | Үйл ажиллагааны зардлаар | 1. Хяналт тавих чиглэлд батлуулсан удирдамжийн тоо 2. Удирдамжийн дагуу хяналт тавьсан эсэх | 1. 1 2. Тийм | Эхний хагас жилд: 1. 1 2. Үгүй Жилийн эцэст: 1. 1 2. Тийм | 1. Эрлийн гэрээний хэрэгжилтийг хангуулах ажлын хүрээнд: Эрлийн ажил гүйцэтгэх гэрээний 3 3.4.10-т заасны дагуу Жейд газ Монголиа ХХК, Хэнсүл констракшн ХХК, Коммон макс ХХК, Ууганбулаг ХХК, Си эйч би ти ти ХХК-ууд тус бүр 1 автомашиныг нийт 5 машиныг АМГТГ-т хүлээлгэн өгсөн. Эрлийн ажил гүйцэтгэх гэрээний 3.4.14-т заасны дагуу Магнетотеллурын судалгааны арга, | 95% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | аргачлал хэрэглээний талаарх сургалтыг Хэнсүл констракшн ХХК 2025.10.03-ны өдөр, Зургийн Arcgis, болон хяналт шинжилгээ статистик мэдээллийн SPSS программын сургалтыг 2025 оны сарын өдрүүдэд Си Эйч Би Ти Ти ХХК тус зохион байгуулсан. (Автомашин болон Сургалтын талаарх мэдээллийг хавсаргав.) 2. Батлагдсан төлөвлөгөөт ажлын гүйцэтгэлд газар дээр нь хяналт тавих ажлын хүрээнд - АМГТГ-ын даргын 2025.11.11-ний өдрийн 111 дүгээр удирдамжийн дагуу мэргэжилтэн С. Дэмбэрэл албан томилолтоор Өвөрхангай аймгийн Баянтээг, Нарийн тээл сумд, Баянхонгор аймгийн Чандмань, Дэлгэр сумын нутаг хамаарах Тахь ресурс ХХК-ийн НДМХ-ийн хайгуулын талбайд өрөмдлөгийн ажлыг газар дээр нь хяналт тавьж ажилласан. - 2025.06.02-ны өдрийн 51 дүгээр удирдамжийн дагуу Л. Мөнгөнтөгс, С.Пүрэвсүрэн нар Дорноговь аймгийн Хатанбулаг сумын нутагт Эргэл XII талбайд өрөмдсөн Смарт1 цооногийн өрөмдлөгийн ажилтай газар дээр нь очиж хяналт тавьж ажилласан. - 2025.11.05-ны өдрийн 112 дугаар удирдамжийн дагуу С.Пүрэвсүрэн Дорноговь аймгийн Мандах сумын нутагт Төхөм X урд талбайд хийгдэж буй 3 хэмжээст чичирхийллийн судалгааны ажилтай 2025.11.12-11.17-ны хооронд газар дээр нь очиж танилцаж хяналт тавьсан. - 2025.10.02 -ны өдрийн 97 дугаар удирдамжийн дагуу Гурван баян ХХХ | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | талбайд өмнө өрөмдсөн 5 цооногийн солилцлыг шалгах ажлаар Ч.Магнайбаяр талбайд ажиллав. - АҮЭБС, БОУАӨС-ын хамтарсан 2025.05.29-ний өдрийн Төхөм Х урд талбайн зарим хэсгийг бүхэлд нь болон хэсэгчлэн буцаах авахад дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийн А/126, А/470 дугаар тушаалаар 3 аймгийн 9 суманд хамаарах талбайд ажиллав.<br>Хүрсэн түвшин: 1. 1 2. Тийм | |
| 3.10. 6 | Газрын тос боловсруулах үйлдвэрийг түүхий эдээр хангахад чиглэж газрын тосны хайгуулыг эрчимжүүлж нөөцийг нэмэгдүүлэх | Үйл ажиллагаа ны зардлаар | Нээлттэй талбайн мэдээллийг бэлтгэж төрийн захиргааны төв байгууллагад мэдээлэл хүргүүлсэн байна | 100% | Эхний хагас жилд: 100% Жилийн эцэст: 100% | Нээлттэй 12 талбайн танилцуулгыг бэлтгэж, нээлттэй зарлах талаар чиглэл хүссэн 2025 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн 1/737 дугаар албан бичгээр АҮЭБЯ-нд хүргүүлэв. Газрын тосны хэтийн төлөвтэй байж болох 7 талбайн мэдээллийг шинээр боловсруулж АҮЭБЯ руу 2025 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн 1/887 дугаар албан бичгээр хүргүүлсэн,Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны 2025 оны 03 сарын 20-ны өдрийн 02/831 албан бичгээр ирүүлсэн чиглэлийн дагуу: 1. Газрын тос, байгалийн хий /уламжлалт бус газрын тос буюу нүүрсний давхаргын метан хий/-н хайгуулын талбай, хайгуулын үйл ажиллагааны өнөөгийн нөхцөл байдлын талаар нээлттэй мэдээлэл /2025-04-07-ны №1/1600/, 2. Газрын тосны хайгуулын ГАЛБА-XI, БАЯНТҮМЭН-XVII, АРБУЛАГ-XXIX, ХӨХНУУР-XVIII талбайн ерөнхий мэдээлэл болон хийгдсэн ажил, үр дүн, ирүүлсэн тайлангийн мэдээлэл /2025-05-22-ны №1/2525/-үүдийг тус тус нэгтгэн "Петрочайна дачин тамсаг" ХХК- | 90% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | д хүргүүлсэн. 3. АҮЭБЯ-ны Газрын тосны бодлогын газраас ирүүлсэн хүсэлтийн хүрээнд хайгуул, ашиглалтын талбайн зургийг 1:1 000 000 масштабтай талбайн мэдээллийг шинэчлэн боловсруулж хүлээлгэн өгсөн. 4. АҮЭБС-ын 2025.10.01-ний өдрийн А/211 дүгээр тушаалаар шинэчлэн баталсан “Газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, ашиглалтын талбайг буцаан өгөх, хүлээн авах журам”-ын 3.6 дахь хэсгийг үндэслэн БХГ-т уламжлалт бус газрын тосны хайгуулын Онги V, Богд IV, Т1, Номгон IX, Гурвантэс XXXV, Тавантолгой XXXIII, газрын тосны хайгуулын Онги V, Матад XX, Төхөм X урд талбайнуудаас хэсэгчлэн болон бүхэлд буцаах ажлын хэсгүүдийн дүгнэлтийг ЭБМЗ-ийн Газрын тосны асуудал хэлэлцэх салбар зөвлөлийн 2025.11.13-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж , "талбайг буцаан авах тухай” ЭБМЗ-ийн 2025.12.04-ний өдрийн ГСХ-2025-02-03 дүгнэлтийг гаргуулсан. 5.Петроматад ХХК нь Дарьганга XXIV талбайд БХГ байгуулахаас татгалзсан тул Засгийн газрын 2025.11.12-ны өдрийн “Тогтоол хүчингүй болгох тухай” 158 дугаар тогтоолоор БХГ байгуулах тухай” 2024.10.23-ны өдрийн 136 дугаар тогтоолыг хүчингүй болгосон.<br>Хүрсэн түвшин: 100% | |
| 3.11. | Газрын тосны тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах ажлыг зохион байгуулах, Бүтээгдэхүүн | Үйл ажиллагааны зардлаар | Санал, дүгнэлтэд үндэслэж, баталсан төлөвлөгөө, төсвийн тоо | 4 | 4 | Ашигт малтмал, газрын тосны газрын даргын 2025 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн А/06 дугаартай тушаалаар байгуулагдсан ажлын хэсэгт ажиллаж | 98.3% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хуваах гэрээнд заасан үйл ажиллагааг явуулж буй аж ахуйн нэгжид хяналт тавина. | | | | | “Петрочайна дачин тамсаг” ХХК-ийн Тосон-Уул XIX, Тамсаг XXI талбайн бүтээгдэхүүн хуваах гэрээний 2024 оны хэрэгжилтийг 2025 оны 02 дугаар сарын 27-ны өдөр, “Доншен газрын тос (Монгол)” ХХК-ийн БХГ97 талбайн гэрээний 2024 оны хэрэгжилтийг 2025 оны 02 дугаар сарын 21-ний өдөр, “Петроматад” ХХК-ийн Матад XX талбайн гэрээний 2024 оны хэрэгжилтийг 2025 оны 03 дугаар сарын 12-ны өдөр тус тус дүгнэж баталгаажуулсан. | |
| 3.11.1 | Тосон-Уул XIX, Тамсаг XXI, Матад XX, 1997 оны Бүтээгдэхүүн хуваах гэрээт талбайн 2025 онд гүйцэтгэх ажлын төлөвлөгөө, төсвийн төслийг судалж, санал дүгнэлт гаргаж, батлуулах | Үйл ажиллагаа ны зардлаар | Санал, дүгнэлтэд үндэслэж, баталсан төлөвлөгөө, төсвийн тоо | 4 | Эхний хагас жилд: Эхний хагас жилд: 4 Жилийн эцэст: Жилийн эцэст: 4 | Ашигт малтмал, газрын тосны газрын даргын 2025 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн А/06 дугаартай тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг: “Петрочайна дачин тамсаг” ХХК-ийн Тосон-Уул XIX, Тамсаг XXI талбайн 2025 оны ажлын төлөвлөгөө, төсвийн төсөлд санал, дүгнэлт өгч, төлөвлөгөө, төсвийг 2025 оны 02 дугаар сарын 27-ны өдөр, “Доншен газрын тос (Монгол)” ХХК-ийн БХГ97 талбайн 2025 оны ажлын төлөвлөгөө, төсвийг 2025 оны 02 дугаар сарын 21-ний өдөр, “Петроматад” ХХК-ийн Матад XX талбайн 2025 оны ажлын төлөвлөгөө, төсвийг 2025 оны 03 дугаар сарын 12-ны өдөр тус тус батлуулсан.<br>Хүрсэн түвшин: 4 | 100% |
| 3.11.2 | Тосон-Уул, Тамсагийн газрын тосны ордуудын нөөцийн хөдөлгөөний тайланг хянах, санал дүгнэлт гаргах | Үйл ажиллагаа ны зардлаар | Санал дүгнэлт гаргаж, хянасан тайлангийн тоо | 2 | Эхний хагас жилд: Эхний хагас жилд: - Жилийн эцэст: | Уул уурхай, хүнд үйлдвэрийн Сайдын 2022 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн А/287 дугаар тушаалаар баталсан “Газрын тосны баялгийн үнэлгээ, нөөцийн тооцооны тайланд тавих шаардлага” журмын дагуу Тосон-Уул, | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Жилийн эцэст: 2 | Тамсагийн газрын тосны ордын нөөцийн тооцооны тайлангийн тодотгол, дахин тооцооллын ажлыг гүйцэтгэж байна. Петрочайна дачин тамсаг ХХК болон нөөцийн үнэлгээ гүйцэтгэж буй компанийн нөөцийн тодотголын төслийг 2024 оны 12 дугаар сард урьдчилсан байдлаар танилцуулсан бөгөөд өнөөдрийн байдлаар гэрээлэгчийн зүгээс монгол хэл рүү хөрвүүлэх ажлыг гүйцэтгэж байна. Доншен газрын тос (Монгол) ХХК-ийн хувьд Зүүнбаян, Цагаан-Элсний ордын газрын тосны нөөцийн дахин тооцооллын тайлангийн төслийг засаж, сайжруулах ажлыг гүйцэтгэж, Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлэх бэлтгэл ажлыг гүйцэтгэж байна.<br>Хүрсэн түвшин: 2 | |
| 3.11.3 | Гэрээлэгчдийн өртөг нөхөгдөх зардлын тайланг хүлээн авах, хянах шалгалтыг гүйцэтгэх. | Үйл ажиллагааны зардлаар | Хянан шалгаж, ҮАГ-т хүргүүлсэн тайлангийн тоо | 4 | Эхний хагас жилд: Эхний хагас жилд: -<br>Жилийн эцэст:<br>Жилийн эцэст : 4 | АМГТГ-ын даргын 2024 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн А/114 дүгээр тушаалаар газрын тосны ашиглалтын Петроматад ХХК-ийн Матад XX, Петрочайна дачин тамсаг Тосон Уул XIX, Тамсаг XXI, Доншен газрын тос (Монгол) ХХК-ийн БХГ 97 талбайн 2023 онд батлагдсан төлөвлөгөө, төсвийн дагуу гүйцэтгэсэн ажил, хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдөх болон нөхөгдсөн зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтын тайланг анхан шатны баримтад үндэслэн хяналт, шалгалтыг хийж, дүгнэлтийн төслийг 2025 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн 3/153, 2025 оны 08 дугаар сарын 05-ны өдрийн 3/3769, 2025 оны 09 дүгээр | 95% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | сарын 19-ний өдрийн 3/4532 дугаар албан бичгүүдээр гэрээлэгчдэд хүргүүлсэн. Ашиглалтын 3 гэрээлэгчийн 4 талбайн хяналт, шалгалтын дүгнэлт, тайланг 2025 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн 1/2105, 08 дугаар сарын 28-ны өдрийн 1/4158, 10 дугаар сарын 20-ны өдрийн 1/5087 дугаартай албан бичгүүдээр УАГ-т хүргүүлсэн.<br>Хүрсэн түвшин: 4 | |
| 3.12. | Газрын тосны ашиглалтын салбарын талаар орон нутагт мэдээлэл, сурталчилгааг түгээх, мэдлэг олгох сургалт зохион байгуулах, иргэд олон нийтэд сурталчлан таниулах ажлыг зохион байгуулна. | Үйл ажиллагаа ны зардлаар | Иргэд олон нийтэд хууль, тогтоомж сурталчлан таниулах чиглэлд зохион байгуулсан арга хэмжээний тоо | 0 | 2 | Дорнод аймгийн засаг дарга асан М.Бадамсүрэн нь 2018 оны 9 дүгээр сард 1 сарын турш газрын тосны экспортын тээврийг орон нутагт үр өгөөжгүй гэж үзэн зогсоож, нутгийн захиргааны байгууллага болон иргэдийн төлөөлөгчдийн шаардлагаар орон нутагтай хамтран ажиллах чиглэлээр 2018.10.29-ний өдөр АМГТГ, Дорнод аймгийн Засаг дарга болон Петрочайна Дачин Тамсаг ХХК-ийн хооронд ‘’Гурван талт хэлцэл’’ түүний “Тэмдэглэл”-ийг 2019-2023 он дуустал 5 жилийн хугацаатайгаар харилцан үзэглэсэн байдаг. Энэхүү Гурван талт хэлцлийн хугацаа дуусгавар болсонтой холбогдуулан Дорнод аймгийн ЗДТГ-аас удаа дараа гэрээг сунгах хүсэлт ирүүлснээр 2019-2023 оны Гурван талт хэлцэл, түүний тэмдэглэлийн хэрэгжилтийг гаргаад байна. Гэвч Гурван талт хэлцлийг дүгнэх уулзалтын товыг орон нутгаас хойшлуулсан. | 70% |
| 3.12.1 | Орон нутагт салбарын мэдээлэл, сурталчилгааг түгээх, | Үйл ажиллагаа | Зохион байгуулсан арга хэмжээний тоо | 0 | Эхний хагас жилд: 0 | Газрын тосны хайгуул, олборлогчдын холбоо ГҮТББ-тай хамтран 2025 оны 9 дүгээр сарын 12-ны өдөр Mining week- | 70% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | мэдлэг олгох сургалт зохион байгуулах, иргэд олон нийтэд сурталчлан таниулах ажлыг зохион байгуулна. | ны зардлаар | | | Жилийн эцэст: 2 | 2025 чуулганд газрын тосны салбарын хайгуул, олборлолтын үйл ажиллагааг сурталчлан таниулах салбар хэлэлцүүлгийг зохион байгуулсан. АМГТГ-аас Газрын тос, байгалийн хийн хайгуул, олборлогчдын холбоотой хамтран газрын тосны салбарын орон нутгийн уулзалт, хэлэлцүүлгийн бэлтгэл ажлыг хангаж, "Зүүн бүсийн зөвлөлдөх уулзалт"-ыг 2025 оны 05 дугаар сарын 01-ний өдөр Чойбалсан хотноо зохион байгуулах саналыг Дорнод аймгийн Засаг даргын Тамгын газарт 2025 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн 1/1771 дугаар албан бичгээр хүргүүлсэн. Гэвч Дорнод аймгийн Засаг даргаас ирүүлсэн хүсэлтийн дагуу хойшлуулсан. Мөн Дорнод аймагт үйл ажиллагаа явуулж буй гэрээлэгч компаниудын өгсөн саналын дагуу 2026 оны 2 дугаар улиралд газрын тосны салбарыг орон нутагт сурталчлан таниулах, хэлцлийг дүгнэх хурлыг зохион байгуулахаар болсон.<br>Хүрсэн түвшин: 2 | |
| 3.13. | Уул уурхайн кадастрын бүртгэл хөтлөх | Үйл ажиллагаа ны зардлаар | Холбогдох хууль тогтоомж, журмын дагуу хийсэн бүртгэлийн хувь | 100% | 100% | Тусгай зөвшөөрлийн талбай буцаах 45, шилжүүлэх 120, сунгах 269, ашиглалтын тусгай зөвшөөрөл хүссэн 35, ТТАМ-ын тусгай зөвшөөрөл хүссэн 331 нийт 787 өргөдөлд зураг зүйн шүүлт хийж 599 өргөдлийн зургийг хэвлэж өгсөн. УУКБС-д бүртгэгдсэн ЗГ-ын тогтоолоор улсын тусгай хэрэгцээнд авсан нийт 29 газар 39869.73 га, Аймаг, сумын ИТХ-ын тогтоолоор орон нутгийн тусгай хэрэгцээнд авсан нийт 24 газар 180.92 га, тусгай хамгаалалтад авсан нийт 29 | 93.3% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | газар 599487.1 га газруудын бүртгэлд хяналт тавьсан. ТТАМ-ын тусгай зөвшөөрөл хүссэн 366 өргөдлөөс 344 өргөдөлд хяналтын хуудас нээн 217 холбогдох шүүлт хийж 189 өргөдлийг татгалзаж, 94 өргөдөлд боломжтой хариу өгч нийт 283 өргөдлийг шийдвэрлэсэн. | |
| 3.13.1 | Ашигт малтмалын тухай хуулийн дагуу тусгай зөвшөөрлийн бүх хөдөлгөөний өргөдлийн талбайд зураг зүйн шүүлт хийх, зураг зүйн бүртгэлд хяналт тавих | Үйл ажиллгааны зардлаар | Кадастрын зураг зүйн шүүлт, бүртгэл хийсэн талбайн тоо | 450 | Эхний хагас жилд: 210 Жилийн эцэст: 290 | Тусгай зөвшөөрлийн талбай буцаах 45, тусгай зөвшөөрөл шилжүүлэх 120, тусгай зөвшөөрлийн хугацаа сунгах 269, шинээр ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл хүссэн 35, түгээмэл тархацтай ашигт малтмалын тусгай зөвшөөрөл хүссэн 331 өргөдлийн зураг зүйн шүүлт хийв. Нийт 787 өргөдөл.<br>Хүрсэн түвшин: 1444 | 100% |
| 3.13.2 | Тусгай хамгаалалт, тусгай хэрэгцээнд авсан газар, Засгийн газрын нөөц газар болон ашигт малтмал эрэх, хайх, ашиглахыг хориглосон, хязгаарласан талбайн бүртгэл хөтлөх | Үйл ажиллагааны зардлаар | Хуульд нийцүүлэн бүртгэсэн тогтоол, шийдвэрийн хувь | 100% | Эхний хагас жилд: 100% Жилийн эцэст: 100% | Уул уурхайн кадастрын бүртгэлд шинээр бүртгэгдсэн Засгийн газрын тогтоолоор улсын тусгай хэрэгцээнд авсан нийт 29 газар 39869.73 га, Аймаг, сумын ИТХ-ын тогтоолоор орон нутгийн тусгай хэрэгцээнд авсан нийт 24 газар 180.92 га, орон нутгийн тусгай хамгаалалтад авсан нийт 29 газар 599487.1 га газруудын бүртгэлд хяналт тавьж ажилласан.<br>Хүрсэн түвшин: 100% | 90% |
| 3.13.3 | Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсэгт заасны дагуу тусгай зөвшөөрөл хүсэж орон нутагт гаргасан | Үйл ажиллагааны зардлаар | Хуульд нийцүүлэн гаргасан дүгнэлтийн хувь | 100% | Эхний хагас жилд: 100% Жилийн эцэст: 100% | 2025 оны 01 дүгээр сарын 01-нээс 12 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар түгээмэл тархацтай ашигт малтмалын тусгай зөвшөөрөл хүссэн 366 өргөдлийг орон нутагт хүлээн авч Уул уурхайн кадастрын бүртгэлийн системд бүртгэж 344 өргөдлийг хянуулахаар кадастрын | 90% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | өргөдлийн дагуу шүүлт хийж, холбогдох дүгнэлт гаргах, хүргүүлэх | | | | | хэлтэст шилжүүлсэн байна. Кадастрын хэлтэс түгээмэл тархацтай ашигт малтмалын тусгай зөвшөөрөл хүссэн 344 өргөдөлд дотоод хяналтын хуудас нээн 217 өргөдөлд геологи хайгуулын хэлтсээр эрдсийн хуримтлалтай эсэхийг шүүлгэхээр хүргүүлсэн. Хориглосон хязгаарласан талбайтай давхцалтай 189 өргөдлийг татгалзаж, 94 өргөдөлд боломжтой хариу өгч шийдвэрлэжээ. Нийт 283 өргөдлийг эцэслэн шийдвэрлэсэн байна.<br>Хүрсэн түвшин: 100% | |
| 3.14. | Ашигт малтмалын тусгай зөвшөөрөлтэй холбоотой өргөдлийн үйлчилгээ үзүүлнэ | Үйл ажиллагаа ны зардлаар | Холбогдох хууль, журамд заасан хугацаанд шийдвэрлэсэн өргөдлийн хувь | 100% | 100% | Тусгай зөвшөөрлийг барьцаалсан, барьцаанаас чөлөөлүүлэх хүсэлт гаргасан 51, тусгай зөвшөөрлийн талбайг бүхэлд нь буцаан авах 6, хэсэгчлэн буцаан авах 39, өргөдлийн шийдвэр, мэдэгдлийн төсөл, тусгай зөвшөөрлийн гэрчилгээ, хавсралтыг дахин олгохыг хүссэн 17, тусгай зөвшөөрлийн ээлжит жилийн төлбөр төлөөгүй хайгуулын 20, ашиглалтын 28 тусгай зөвшөөрөл, нийт 48 тусгай зөвшөөрлийг цуцлах шийдвэр мэдэгдлийн төслийг хянав. тусгай зөвшөөрөл эзэмшигчээс ирүүлсэн хүсэлтийн дагуу 250 гаруй хуулийн этгээдийн хаяг, эзэмшигчийн мэдээллийг бүртгэсэн бүртгэлийг хянасан. Барьцаалсан ашиглалтын 10, хайгуулын 1 тусгай зөвшөөрөл, барьцаалсныг дуусгавар болсон ашиглалтын 12, хайгуулын 1, давхар барьцаалсан 23 тусгай зөвшөөрөл, барьцааныг бүртгэхээс татгалзсан 4 тусгай зөвшөөрөл, талбайг бүхэлд нь | 97.5% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | болон хэсэгчлэн буцаан өгөх 45 өргөдөл ирүүлснийг хянаж 33 өргөдлийн талбайг буцаан авч 6 өргөдлийг татгалзаж шийдвэрлэсэн. Тусгай зөвшөөрлийн хугацааг сунгуулах нийт 259 өргөдөл ирүүлснээс хайгуулын 250 тусгай зөвшөөрлийг сунгаж, баримт бичгийн бүрдэл дутуу хайгуулын 8, ашиглалтын 1 тусгай зөвшөөрлийг сунгахаас татгалзаж шийдвэрлэсэн, ашиглалтын 57, хайгуулын 58 нийт 115 тусгай зөвшөөрлийг шилжүүлэх бүртгэснээс 90 өргөдөл, хянагдаж байгаа 20 өргөдөл, тусгай зөвшөөрлийн гэрчилгээ, хавсралт дахин олгох 14, дахин олгохоос татгалзсан 3 өргөдлийг хянаж шийдвэрлэснийг УУКБСистемд бүртгэж цахим архивд холбож шийдвэрийн дагуух мэдэгдлийг тухай бүр хүргүүлэн байгууллагын цахим хуудас болон өдөр тутмын сониноор дамжуулан олон нийтэд тухай бүр мэдээлсэн. Шинээр олгосон ашигт малтмалын ашиглалтын 33, хайгуулын 87 тусгай зөвшөөрлийн хувийн хэргийг үүсгэсэн. Тусгай зөвшөөрлийн хөдөлгөөний 469 өргөдлийн, тусгай зөвшөөрлийн ээлжит жилийн төлбөрийн 2444 баримт бүртгэсэн материалыг хувийн хэрэгт баяжилт хийж, 148 тусгай зөвшөөрлийн хувийн хэргийг сонирхсон этгээдүүдэд танилцуулсан. Цацраг идэвхт ашигт малтмалын тусгай зөвшөөрөлтэй холбоотой мэдээллийг хянан Цөмийн энергийн комиссын ажлын албанд хүргүүлсэн. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3.14.1 | Тусгай зөвшөөрөл барьцаалах, барьцаанаас чөлөөлөх өргөдлийг хянан шийдвэрлэх | Үйл ажиллагааны зардлаар | Хуульд нийцүүлэн бүртгэж, шийдвэрлэсэн өргөдлийн хувь | 100% | Эхний хагас жилд: 100% Жилийн эцэст: 100% | 2025 оны жилийн эцсийн байдлаар тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдээс ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг банк болон банк санхүүгийн байгууллагад барьцаалсан, давхар барьцаалсан болон барьцааны гэрээ дуусгавар болсныг бүртгүүлэхээр төрийн захиргааны байгууллагад гаргасан 51 өргөдлийн материалтай танилцаж, тусгай зөвшөөрлийг барьцаанд бүртгэх, бүртгэхээс татгалзах болон барьцааны гэрээ дуусгавар болсныг бүртгэх шийдвэр мэдэгдлийн төслийг хянав. 1. Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг банк болон банк санхүүгийн байгууллагад барьцаалсан ашиглалтын 10, хайгуулын 1 тусгай зөвшөөрлийг, 2. Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг банк болон банк санхүүгийн байгууллагад барьцаалсныг дуусгавар болсон ашиглалтын 12, хайгуулын 1 тусгай зөвшөөрлийг, 3. Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг банк болон банк санхүүгийн байгууллагад давхар барьцаалсан ашиглалтын 23 тусгай зөвшөөрлийг, 4. Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг банк болон банк санхүүгийн байгууллагад барьцаалсныг бүртгэхээс татгалзсан 4 тусгай зөвшөөрлийг тус тус Уул уурхайн кадастрын бүртгэлийн системд бүртгэсэн байна.<br>Хүрсэн түвшин: 100% | 100% |
| 3.14.2 | Тусгай зөвшөөрлөөр олгогдсон талбайг | Үйл ажиллагаа | Хуульд нийцүүлэн бүртгэж, | 100% | Эхний хагас жилд: 100% | Нийт талбайг бүхэлд нь болон хэсэгчлэн буцаан өгөх 45 өргөдөл ирүүлснийг хянаж 33 өргөдлийн талбайг буцаан авч | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | буцаан өгөх өргөдлийг хянан шийдвэрлэх | ны зардлаар | шийдвэрлэсэн өргөдлийн хувь | | Жилийн эцэст: 100% | 6 өргөдлийг татгалзаж шийдвэрлэн, 6 өргөдөл хяналтын шатанд явж байгаа болно. 1.Ашигт малтмалын тухай хуулийн 54 дүгээр зүйлд заасны дагуу 6 аж ахуйн нэгжээс ирүүлсэн тусгай зөвшөөрлийн талбайг бүхэлд нь буцаан өгөх өргөдлийн материалтай танилцаж, Кадастрын хэлтсийн даргын тусгай зөвшөөрлийн талбайг бүхэлд нь буцаан авах 6 шийдвэр, мэдэгдлийн төслийг хянав. 2.Ашигт малтмалын тухай хуулийн 55 дугаар зүйлд заасны дагуу 33 аж ахуйн нэгжээс ирүүлсэн тусгай зөвшөөрлийн талбайг хэсэгчлэн буцаан өгөх өргөдлийн материалтай танилцаж, Кадастрын хэлтсийн даргын тусгай зөвшөөрлийн талбайг хэсэгчлэн буцаан авах 33 мэдэгдлийн төслийг хянав. 6 тусгай зөвшөөрлийн талбайг хэсэгчлэн буцаан авах шийдвэр, мэдэгдлийн төсөл хянагдаж байна.<br>Хүрсэн түвшин: 100% | |
| 3.14.3 | Тусгай зөвшөөрлийг шилжүүлэх өргөдлийг хянан шийдвэрлэх | Үйл ажиллагаа ны зардлаар | Хуульд нийцүүлэн бүртгэж, шийдвэрлэсэн өргөдлийн хувь | 100% | Эхний хагас жилд: 100% Жилийн эцэст: 100% | 2025 оны жилийн эцсийн байдлаар Ашигт малтмалын тухай хуулийн 49, 50, 52 дугаар зүйлд заасны дагуу тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдээс ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг бүхэлд нь болон хэсэгчлэн шилжүүлэх нийт 115 өргөдөл ирүүлснийг хүлээн авч Уул уурхайн кадастрын бүртгэлийн системд /CMCS/ бүртгэснээс ашиглалтын 57 тусгай зөвшөөрөл, хайгуулын 58 тусгай зөвшөөрлийн шилжүүлгийн өргөдлийг бүртгэсэн байна. Үүнээс 90 өргөдлийг хянан шийдвэрлэсэн байна. Хянан | 90% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | шийдвэрлэх шатанд 20 өргөдөл бүртгэлтэй байна.<br>Хүрсэн түвшин: 100% | |
| 3.14.4 | Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг цуцлах, хугацаа дуусгавар болсныг бүртгэх | Үйл ажиллагааны зардлаар | Хуульд нийцүүлэн шийдвэрлэсэн тусгай зөвшөөрлийн хувь | 100% | Эхний хагас жилд: 100% Жилийн эцэст: 100% | 2025 оны жилийн эцсийн байдлаар тусгай зөвшөөрлийн ээлжит жилийн төлбөрийг Ашигт малтмалын тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.7 дахь хэсэгт заасан хугацаанд төлөөгүй ашигт малтмалын хайгуулын 20, ашиглалтын 28 тусгай зөвшөөрөл, нийт 48 тусгай зөвшөөрлийг цуцлах шийдвэрийн төслийг хянав. Цуцлагдсан тусгай зөвшөөрлийг Уул уурхайн кадастрын бүртгэлийн системд бүртгэж, хяналтын хуудас болон холбогдох баримт бичгийг тусгай зөвшөөрлийн цахим архивд холбов. Тусгай зөвшөөрөл эзэмшигчид шийдвэрийн дагуух мэдэгдлийг тухай бүр хүргүүлж, байгууллагын цахим хуудас болон өдөр тутмын сониноор дамжуулан олон нийтэд тухай бүр мэдээлэв.<br>Хүрсэн түвшин: 100% | 100% |
| 3.15. | Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл шинээр олгох | Үйл ажиллагааны зардлаар | Холбогдох хууль, журмын нийцүүлэн олгосон талбай, тусгай зөвшөөрлийн хувь | 100% | 100% | 2025 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар сонгон шалгаруулалт зарлах боломжтой талбайд аймаг нийслэлийн засаг даргаас санал авах бэлтгэлийг бүрэн хангаад байна. Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн хуралдааны тэмдэглэлд ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл олголтод дүн шинжилгээ хийх, дүгнэлт гаргах, дүгнэлтийг үндэслэн тусгай зөвшөөрөл олгох эсэхийг танилцуулж байх, дүгнэлтгүй | 95% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | тохиолдолд зөвшөөрөл олгохгүй байхыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн (хуучин нэрээр) сайдад даалгасны дагуу Ашигт малтмал, газрын тосны газар болон Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газрын дарга нарын 2024 оны 09 дүгээр сарын 10-ны өдрийн А/99, А/260 дугаар хамтарсан тушаалаар тэмдэглэлд дурдсан ажиллагааг хийх хамтарсан ажлын хэсгийг байгуулсан. Ажлын хэсгийн хүрээнд хийгдсэн ажил, санал дүгнэлтийн талаар 2025 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн 1/792 дугаартай албан бичгийг Аж үйлдвэр, эрдэс баялгийн яаманд хүргүүлэхэд хяналт тавсан Тус яамнаас 2025 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн 02/626, 03 дугаар сарын 14-ний өдрийн 02/776, 04 дүгээр сарын 15-ны өдрийн 02/1136, 04 дүгээр сарын 28-ны өдрийн 02/1291, 09 дүгээр сарын 08-ны өдрийн 02/2561, 10 дугаар сарын 07-ны өдрийн 02/2853, 10 дугаар сарын 09-ний өдрийн 02/2899, 11 дүгээр сарын 18-ны өдрийн 02/3287 дугаартай албан бичгүүдээр хайгуулын тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалт явуулах талбайн жагсаалт, мэдээллийг ирүүлсний дагуу сонгон шалгаруулалт зохин явуулж байна. АМТХуулийн 25, 26 дугаар зүйлд заасны дагуу аж ахуйн нэгжээс ирүүлсэн 41 ашиглалтын тусгай зөвшөөрөл хүссэн өргөдлөөс 33 өргөдлийн материалтай танилцаж Кадастрын хэлтсийн даргын ашиглалтын тусгай зөвшөөрөл олгох 33 шийдвэр, мэдэгдлийн төслийг хянав. /эдгээр өргөдлүүдээс өмнөх онуудад бүртгэсэн | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 4 өргөдөлд ашиглалтын тусгай зөвшөөрөл олгосон байна, өмнөх онуудад бүртгэсэн 5 тусгай зөвшөөрлийг татгалзаж өргөдлийн бүртгэлээс хассан бүртгэлтэй байна. 2025 онд бүртгэсэн 8 өргөдөл хяналтын үйл ажиллагаа үргэлжилж байна. | |
| 3.15.1 | Сонгон шалгаруулалтын журмаар ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааг зохион байгуулах | Үйл ажиллагааны зардлаар | Сонгон шалгаруулалтаар олгох талбайг ялгаж бэлтгэн Ашигт малтмалын тухай хуулийн 17 дугаар зүйлд заасны дагуу орон нутгаас албан бичгээр санал авах, орон нутгаас ирүүлсэн саналыг нэгтгэн АҮЭБЯ-нд хүргүүлэх, тусгай зөвшөөрөл олгох | Батлагдсан талбайн хувь | Эхний хагас жилд: 100% Жилийн эцэст: 100% | 2025-12-01-ний байдлаар сонгон шалгаруулалт зарлах боломжтой талбайд аймаг нийслэлийн засаг даргаас санал авах бэлтгэлийг бүрэн хангаад байна. ЗГ-ын 2024-05-15-ны хуралдааны тэмдэглэлд тусгай зөвшөөрөл олголтод дүн шинжилгээ хийх, дүгнэлт гаргах, дүгнэлтийг үндэслэн тусгай зөвшөөрөл олгох эсэхийг танилцуулж байх, дүгнэлтгүй тохиолдолд зөвшөөрөл олгохгүй байхыг УУХҮ (хуучин нэрээр) сайдад даалгасны дагуу АМГТГ болон ГЗБГЗЗГазрыг дарга нарын 2024-09-10-ны А/99, А/260 дугаар хамтарсан тушаалаар ажлын хэсгийг байгуулсан. Ажлын хэсгийн хийсэн ажил, санал дүгнэлтийн талаар 2025-02-13-ны 1/792 албан бичгийг АҮЭБЯам-д хүргүүлэсэн Тус яамнаас 2025-02-25-ны 02/626, 03-14-ний 02/776, 04-15-ны 02/1136, 04-28-ны 02/1291, 09-08-ны 02/2561, 10-07-ны 02/2853, 10-09-ний 02/2899, 11-18-ны 02/3287 дугаартай албан бичгүүдээр хайгуулын тусгай зөвшөөрөл олгох СШ-т явуулах талбайн жагсаалт, мэдээллийг ирүүлсний дагуу СШ явуулсан. АМГТГ-ын даргын 2025-02-27-ны А/38-р СШ-67 дугаарын 20 талбай, 2025-03-11-ны А/44-р СШ-68 дугаарын 10 талбай, 2025-03-14-ны А/48-р СШ-69 дугаарын 8 талбай, 2025- | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 04-02-ны А/56-р СШ-70 дугаарын 10, СШ-71 дугаарын 2025-04-08-ны А/62-ын 13 талбай. Нийт 60 талбайн 144 мэдэгдлийн төслийг, АМГТГ-ын даргын 2025-02-27-ны А/38-р СШ-67 дугаарын 20 талбай, 2025-03-11-ны А/44-р СШ-68 дугаарын 10 талбай, 2025-03-14-ны А/48-р СШ-69 дугаарын 8 талбай, 2025-04-02-ны А/56-р СШ-70 дугаарын 10, СШ-71 дугаарын 2025-04-08-ны А/62-ын 13 талбай. Нийт 60 талбайн 144 шалгарсан болон шалгараагүй тухай мэдэгдлийн төслийг, АМГТГ-ын даргын 2025-02-27-ны А/38-р СШ-67 дугаарын 20 талбай, 2025-03-11-ны А/44-р СШ-68 дугаарын талбай, 2025-03-14-ны А/48-р СШ-69 дугаарын 8 талбай, 2025-04-02-ны А/56-р СШ-70 дугаарын СШ-71 дугаарын 2025-04-08-ны А/62, СШ-72 дугаарын 2025-04-23-ны А/71, СШ-73 дугаарын 2025-05-07-ны А/81, СШ-74 дугаарын 2025-05-15-ны А/88, СШ-75 дугаарын 2025-05-21-ны А/97, СШ-7 СШ-76 дугаарын 2025-05-29-ны А/100 нийт 111 талбай СШ зарлах тушаалын төслийг цахим системд бүртгэв.<br>Хүрсэн түвшин: 100% | |
| 3.15.2 | Ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл шинээр олгох ажлыг зохион байгуулах | Үйл ажилгааны зардлаар | Хуульд нийцүүлэн бүртгэж, шийдвэрлэсэн өргөдлийн хувь | 100% | Эхний хагас жилд: 100% Жилийн эцэст: 100% | 2025 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн байдлаар Ашигт малтмалын тухай хуулийн 25, 26 дугаар зүйлд заасны дагуу аж ахуйн нэгжээс ирүүлсэн 41 ашиглалтын тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөл ирүүлсэн. Үүнээс 33 өргөдлийн материалтай танилцаж, Кадастрын хэлтсийн даргын ашиглалтын тусгай зөвшөөрөл олгох 33 шийдвэр, мэдэгдлийн төслийг хянав. /эдгээр | 90% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | өргөдлүүдээс өмнөх онуудад бүртгэсэн 4 өргөдөлд ашиглалтын тусгай зөвшөөрөл олгосон байна, өмнөх онуудад бүртгэсэн 5 тусгай зөвшөөрлийг татгалзаж өргөдлийн бүртгэлээс хассан бүртгэлтэй байна. 2025 онд бүртгэсэн 8 өргөдөл хяналтын үйл ажиллагаа үргэлжилж байна.<br>Хүрсэн түвшин: 100% | |
| 3.16. | Орон нутагт салбарын мэдээлэл, сурталчилгааг түгээх, мэдлэг олгох сургалт зохион байгуулах, иргэд олон нийтэд сурталчлан таниулах ажлыг зохион байгуулна. | Үйл ажиллагааны зардлаар. | Иргэд олон нийтэд хууль, тогтоомж сурталчлан таниулах ажлын тоо | 6 | 10 | 1. ОНТХГ-ын Говийн бүсийн төлөөлөгчийн газраар дамжуулан Дундговь аймгийн Баянжаргалан сум, Өмнөговь аймгийн Баяндалай, Баян-Овоо, Мандал-Овоо сумдад ажиллаж ОНТХГ-ын зорилго, зорилтыг танилцуулж ажилласан. 2.АМГТГ-ын даргын хөдөө орон нутагт ажиллах ажлын удирдамж - Говийн бүсийн төлөөлөгчийн газраар дамжуулан Дундговь аймгийн Хулд, Луус,Гурвансайхан,Баянжаргалан сумдад нутгийн өөрөө удирдах байгууллага,Засаг даргын тамгын газрын холбогдох газар,хэлтсүүд,иргэдэд мэдээ мэдээлэл хүргүүлэн ажилласан. 3.АМГТГ-ын даргын хөдөө орон нутагт ажиллах ажлын удирдамж-105 дугаарын дагуу Дундговь аймгийн Сайхан-Овоо сумын нутагт ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжийн хүсэлтийн дагуу тус сумын Засаг даргын тамгын газар дээр очиж нутгийн удирдлагатай уулзан ОНДТХГ-ын чиг үүргийн танилцуулж ажилласан. 4. АМГТГ-ын даргын хөдөө орон нутагт ажиллах ажлын удирдамж-116 Хангай-2 | 90% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | бүсийн төлөөлөгчийн газар Өвөрхангай аймгийн Уянга, Тарагт сумдад ажиллах удирдамжийн дагуу ОНТХГ-ын зорилго, зорилтыг танилцуулж ажилласан. 5. Ховд аймгийн Дарви сумын 2 багийн ИНХ, Зэрэг сумын ЗДТГ-ын мэргэжилтнүүд болон иргэдэд, Увс аймгийн Өмнөговь сумын Намир багийн ИНХ-д, Баян-Өлгий аймгийн ЗДТГ-ын болон байгаль орчны байгууллагуудын холбогдох мэргэжилтнүүдэд төлөөлөгчийн газрын үйл ажиллагааны талаар танилцуулж ажилласан. 6.ОНТХГ-ын Төвийн бүсийн төлөөлөгчийн газраас бүсийн хэмжээнд газрын тосны тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжүүдтэй 2025 оны 06 дугаар сарын 26-ны өдөр уулзалт хэлэлцүүлгийг төв оффистой хамтран зохион байгуулсан. Энэхүү онлайн уулзалтад Бүтээгдэхүүний хэлтсийн дага Д.Даваабаяр холбогдох мэргэжилтэн Д.Дагвасүрэн ГТХХ-ийн ахлах мэргэжилтэн Р.Болд-Эрдэнэ, ОНТХГ-ын ахлах мэргэжилтэн Б.Болорцэцэг, ГТБХ мэргэжилтэн Б.Эрдэнэчулуун нар оролцсон. | |
| 3.16. 1 | АМГТГ-ын Орон нутаг дахь төлөөлөл хариуцсан газрын зорилго, зорилтыг танилцуулах, бүс нутгийн хэмжээнд очиж ажиллах, чиг үүргийн холбогдох байгууллагуудад сургалт зохион | Үйл ажиллагаа ны зардлаар | Зохион байгуулсан сургалтын тоо (өссөн дүнгээр) | 6 | Эхний хагас жилд: 5 Жилийн эцэст: 10 | 1. НҮБ-ын ИНТЕГРА Оролцоо төсөлд тус газрын ахлах мэргэжилтэн Б.Болорцэцэгийн сертификат нийт бүсүүддээ төслийг санал болгож, 5 төслийн материал илгээснээс төв болон баруун бүсийн бичсэн 2 төсөл шалгарч 2025 оны 7 дугаар сарын 3-нд 59 сая төгрөгийн сертификат гардан авсан. Төсөл амжилттай үргэлжилж байна. 2.АМГТГ-ын даргын хөдөө орон нутагт ажиллах ажлын удирдамж - Говийн | 90% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | байгуулах, мэдээлэл өгөх | | | | | бүсийн төлөөлөгчийн газраар дамжуулан Дундговь аймгийн Хулд, Луус, Гурвансайхан, Баянжаргалан сумдад нутгийн өөрөө удирдах байгууллага, Засаг даргын тамгын газрын холбогдох газар,хэлтсүүд, иргэдэд мэдээ мэдээлэл хүргэн ОНТХГ-ын зорилго, зорилтыг танилцуулж ажилласан. 3.АМГТГ-ын даргын хөдөө орон нутагт ажиллах ажлын 105 дугаарын удирдамж дагуу Дундговь аймгийн Сайхан-Овоо сумын нутагт ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжийн хүсэлтийн дагуу тус сумын Засаг даргын тамгын газар дээр очиж нутгийн удирдлагатай уулзан ОНДТХГ-ын чиг үүргийн танилцуулж ажилласан. 4. АМГТГ-ын даргын хөдөө орон нутагт ажиллах ажлын 116 дугаар удирдамжийн дагуу Хангай-2 бүсийн төлөөлөгчийн газар Өвөрхангай аймгийн Уянга, Тарагт сумдад ажиллаж ОНТХГ-ын зорилго, зорилтыг танилцуулж цаашид хэрхэн хамтран ажиллах талаар санал солилцож ажилласан. 5. Ховд аймгийн Дарви сумын 2 багийн ИНХ, Зэрэг сумын ЗДТГ-ын мэргэжилтнүүд болон иргэдэд мөн Увс аймгийн Өмнөговь сумын Намир багийн ИНХ-д, Баян-Өлгий аймгийн ЗДТГ болон байгаль орчны холбогдох мэргэжилтнүүдэд төлөөлөгчийн газрын үйл ажиллагааны талаар танилцуулж ажилласан. 6. ОНТХГ-ын Говийн бүсийн төлөөлөгчийн газраар дамжуулан Дундговь аймгийн Баянжаргалан сум, Өмнөговь аймгийн Баяндалай, Баян-Овоо, Мандал-Овоо | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | сумдад ажиллаж ОНТХГ-ын зорилго, зорилтыг танилцуулж ажилласан.<br>Хүрсэн түвшин: 6 | |
| 3.16.2 | “Ил тод хариуцлагатай уул уурхай” бүсийн чуулга уулзалтыг зохион байгуулах | Үйл ажиллагааны зардлаар | Зохион байгуулсан чуулга уулзалтын тоо | 2 | Эхний хагас жилд: 1<br>Жилийн эцэст: 1 | 1. Дорноговь аймгийн Засаг даргын тамгын газар Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам, АМГТГ, Монголын Уул Уурхайн Үндэсний Ассоциацитай хамтран “Хариуцлагатай Уул Уурхай” чуулга уулзалтыг 2025 оны 04 дүгээр сард зохион байгуулахаар төлөвлөж буйтай холбогдуулан бүсийн төлөөлөгчийн газар болон ОНДТХГ-ын албан хаагчид ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн судалгаа болон шаардлагатай мэдээ мэдээллийг бэлтгэн ажилласан боловч Засгийн газраас зохион байгуулсан Говийн бүсийн бүсчилсэн хөгжлийн Анхдугаар зөвлөгөөн уулзалт давхацсан тул дээрхи чуулга уулзалт 2025 онд зохион байгуулагдах боломжгүй болсон. Иймд ирэх 2026 оны төлөвлөгөөнд тусган ажиллахаар дахин төлөвлөсөн болно. 2. ОНДТХГ-ын Хойд бүсийн төлөөлөгчийн газар 2025 оны 9-р сарын 25,26-ны өдрүүдэд Дархан-Уул аймагт Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам, Ашигт малтмал, газрын тосны газар, Уул уурхайн үндэсний ассоциациас зохион байгуулсан “Хариуцлагатай уул уурхай” сэдэвт өдөрлөгт оролцож "Уул уурхай Орон нутгийн харилцаа" сэдвээр илтгэл тавьсан. Уг илтгэлд тухайн бүс нутгийн ашигт малтмалын ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрлийн мэдээлэл болон газрын тосны бүтээгдэхүүний талаар танилцуулсан. | 90% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Хүрсэн түвшин: 2 | |
| 3.17. | Цөмийн болон цацрагийн хяналтын чиглэлээр төлөвлөгөөт, урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг хэрэгжүүлнэ. | Үйл ажиллагаа ны зардлаар | Хяналт шалгалтад хамрагдсан объектын гүйцэтгэлийн хувь | 75 | 100 | Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Цөмийн болон цацрагийн хяналтын салбарын улсын ерөнхий байцаагчийн баталсан 06-00/012, 06-00/013 тоот 2 удирдамжийн хүрээнд Төлөвлөгөөт хяналт шалгалтыг, 06-00/005,06-00/006, 06-00/007, 06-00/008, 06-00/009, 06-00/010 тоот 6 удирдамжийн хүрээнд Урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг тус тус хэрэгжүүллээ. 1.Төлөвлөгөөт хяналт шалгалтын 2 удирдамжийн хүрээнд шалгалтад нийт 60 аж ахуй нэгж байгууллагыг хамруулж, 680 зөрчил илрүүлж,10 цацрагийн үүсгүүр, рентген аппаратын ашиглалтыг түр зогсоож, зөрчил дутагдлыг арилгуулахаар 402 заалттай улсын байцаагчийн 55 албан шаардлага, ноцтой зөрчил гаргасан 3 хуулийн этгээдэд зөрчлийн хэрэг нээж, 9 сая төгрөгийн шийтгэл оногдуулж, хугацаанд нь барагдуулан эрх бүхий албан тушаалтны 3 албан даалгавар хүргүүлж, хэрэгжилтэд нь хяналт ажилласан. 2. Урьдчилан сэргийлэх хяналт шалгалтын 6 удирдамжийн хүрээнд: - Мэргэжлийн шарлагын хяналтад 430 байгууллагын 1673 цацрагтай ажиллагчийг хамруулж - Тусгай зөвшөөрөлгүй цацрагийн үүсгүүрийг 19 бууруулсан - Улаанбаатар хотын төвлөрсөн усан хангамжийн 9 эх үүсвэр, Дорнод аймгийн Дорнод нийтийн аж ахуй ОНӨААТУГ-аас ундны усны нийт 60 дээж - ХАБҮЛЛ-ийн Цацрагийн хяналтын лаборатори, Улсын мал эмнэлэг ариун цэврийн төв | 95% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | лабораториудад 2025 онд импортын хүнсний бүтээгдэхүүний 7 нэр төрлийн 374 дээж -Дорнод бүсийн эрчим хүчний систем ТӨХК, Дулааны цахилгаан станц (ДЦС) –ууд II, III, IV, Амгалан дулааны станц, Сэлбэ дулааны станцын зуухны үнс, хаягдал үнсэн сангийн үнснээс 17 дээж, үнсэн сан орчмын хөрсний 3 дээж нийт 20 дээж - Геологи хайгуулын чиглэлээр цацрагийн үүсгүүр хадгалах байргүй ч цацраг идэвхт үүсгүүр ашиглаж буй 7 аж ахуйн нэгжийн нийт 8 цацраг идэвхт үүсгүүрийг хадгалалтад шилжүүлэхэд хяналт тавьж, Нийслэлд цацраг идэвхт үүсгүүр хадгалах байртай 8 аж ахуйн нэгжээс цацраг идэвхт үүсгүүрийг хөдөө орон нутагт тээвэрлэх, шилжилт хөдөлгөөн хийсэн талаарх нийт 53 мэдэгдлийг хүлээн авч, урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг хэрэгжүүлсэн. | |
| 3.17.1 | Цөмийн болон цацрагийн хяналтын чиглэлээр их, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн 60 аж ахуйн нэгжид төлөвлөгөөт шалгалт хийх | Үйл ажиллагааны зардлаар | Хууль сахин мөрдөлтийн хувь /өссөн дүнгээр/ | 80 | Эхний хагас жилд: 81 Жилийн эцэст: 82 | Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Цөмийн болон цацрагийн хяналтын салбарын улсын ерөнхий байцаагчийн баталсан 06-00/012, 06-00/013 тоот 2 удирдамжийн хүрээнд шалгалтад нийт 60 аж ахуй нэгж байгууллагад шалгалт хийж, 06.17 кодтой Цацрагийн үүсгүүрийн аюулгүй ажиллагааг шалгах хяналтын хуудас, 6.19 кодтой “Рентген багаж, тоног төхөөрөмжийн цацрагийн аюулгүй ажиллагааг шалгах хяналтын хуудас”, 6.18 кодтой “Рентген оношилгооны цацрагийн аюулгүй ажиллагааг шалгах хяналтын хуудас”-аар шалгахад нийт 680 зөрчил, дутагдал илэрч, бага эрсдэлтэй 30, дунд эрсдэлтэй 21, их эрсдэлтэй 7 аж ахуйн | 90% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | нэгж үнэлэгдэж, 2 байгууллага үйл ажиллагаа зогсоосон ба хяналт шалгалтын хууль сахин мөрдөлтийн хувь 77 байна. Хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулахаар 402 заалттай улсын байцаагчийн 55 албан шаардлага өгч, 10 цацрагийн үүсгүүр, рентген аппаратын ашиглалтыг түр зогсоож, ноцтой зөрчил гаргасан 3 хуулийн этгээдэд зөрчлийн хэрэг нээж, 9 сая төгрөгийн шийтгэл оногдуулж, хугацаанд нь барагдуулан эрх бүхий албан тушаалтны 3 албан даалгавар хүргүүлж, хэрэгжилтэд нь хяналт ажилласан.<br>Хүрсэн түвшин: 77 | |
| 3.17.2 | Цөмийн болон цацрагийн хяналтын 6 чиглэлээр урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх | Үйл ажиллагааны зардлаар | 1. Гүйцэтгэлийн хувь /өссөн дүнгээр/ | 70 | Эхний хагас жилд: 75 Жилийн эцэст: 100 | Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Цөмийн болон цацрагийн хяналтын салбарын улсын ерөнхий байцаагчийн баталсан 06-00/005,06-00/006, 06-00/007, 06-00/008, 06-00/009, 06-00/010 тоот 6 удирдамжийн хүрээнд: - Мэргэжлийн шарлагын хяналтад 430 байгууллагын 1673 цацрагтай ажиллагчийг хамруулсан. - Тусгай зөвшөөрөлгүй цацрагийн үүсгүүрийг 19 бууруулсан. - Улаанбаатар хотын төвлөрсөн усан хангамжийн 9 эх үүсвэр, Дорнод аймгийн Дорнод нийтийн аж ахуй ОНӨААТУГ-аас ундны усны нийт 60 дээжийг цацрагийн шинжилгээнд хамруулсан. - ХАБҮЛЛ-ийн Цацрагийн хяналтын лаборатори, Улсын мал эмнэлэг ариун цэврийн төв лабораториудад 2025 онд импортын хүнсний бүтээгдэхүүний 7 нэр төрлийн | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 374 дээж цацрагийн шинжилгээнд хамруулсан. -Дорнод бүсийн эрчим хүчний систем ТӨХК, Дулааны цахилгаан станц (ДЦС) –ууд II, III, IV, Амгалан дулааны станц, Сэлбэ дулааны станцын зуухны үнс, хаягдал үнсэн сангийн үнснээс 17 дээж, үнсэн сан орчмын хөрсний 3 дээж нийт 20 дээж цацрагийн шинжилгээнд хамруулсан. -Геологи хайгуулын чиглэлээр цацрагийн үүсгүүр хадгалах байргүй ч цацраг идэвхт үүсгүүр ашиглаж буй 7 аж ахуйн нэгжийн нийт 8 цацраг идэвхт үүсгүүрийг хадгалалтад шилжүүлэхэд хяналт тавьж, Нийслэлд цацраг идэвхт үүсгүүр хадгалах байртай 8 аж ахуйн нэгжээс цацраг идэвхт үүсгүүрийг хөдөө орон нутагт тээвэрлэх, шилжилт хөдөлгөөн хийсэн талаарх нийт 53 мэдэгдлийг хүлээн авч, урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг хэрэгжүүлсэн.<br>Хүрсэн түвшин: 100 | |
| 3.18. | Нүүрс, нүүрсэн бүтээгдэхүүнд чанарын хяналтын шинжилгээ хийх | Үйл ажиллагааны зардлаар | Хууль журамд заасан хугацаанд шийдвэрлэсэн хүсэлтийн хувь | 100% | 100% | Тайлангийн хугацаанд захиалагч байгууллагуудаас нийт 268 дээж ирүүлснээс сайжруулсан хатуу түлш – 23 дээж, нүүрс болон нүүрсэн бүтээгдэхүүн – 245 дээжийг хүлээн авсан. Дээрх дээжид техникийн болон коксжих шинж чанарын шинжилгээг стандартын дагуу гүйцэтгэж, сорилтын тайланг лабораторийн эрхлэгчээр баталгаажуулан, шинжилгээний үр дүнг аж ахуйн нэгж, байгууллагуудад цахимаар болон цаасан хэлбэрээр хүргүүлэн ажилласан. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3.18. 1 | Сайжруулсан хатуу түлш, нүүрс нүүрсэн бүтээгдэхүүний техникийн болон коксжих шинж чанар бусад шинжилгээг хийх | Үйл ажиллагааны зардлаар | Хууль журамд заасан хугацаанд шийдвэрлэсэн хүсэлтийн хувь | 100% | Эхний хагас жилд: 100% Жилийн эцэст: 100% | Сайжруулсан хатуу түлш, нүүрс нүүрсэн бүтээгдэхүүн”-ий нийт 268 дээжийг шинжилгээнд хамруулсан. 1. Шинжилгээнд хамруулсан дээж - Нийслэлийн агаар, орчны бохирдолтой тэмцэх газар (https://aprd.ub.gov.mn) ирүүлсэн дээжийн тоо - 1 дээж (Шахмал 1, ) - Аж ахуй нэгжийн -246 дээж ( Шахмал 1, нүүрс-245) - Таван толгой түлш ХХК ирүүлсэн дээжийн тоо -21 дээж (Шахмал 16, миддлинг 5) - Дотоод хяналт-5 дээж 2.Шинжилсэн стандарт арга аргачлал: - MNS GB/T 212, Нүүрсний техникийн шинжилгээний арга - MNS 0655, Хүрэн, чулуун нүүрс, антрацит ба шатах занар, Чийгийг тодорхойлох арга - MNS 0652, Хүрэн, чулуун нүүрс, антрацит ба шатах занар, үнслэг тодорхойлох арга - MNS 0564, Хүрэн ба чулуун нүүрс, антрацит дэгдэмхий бодисын гарцыг тодорхойлох - MNS ISO 1928, Хатуу эрдэс түлшний илчлэгийн нийт утгыг бортогон калориметрийн аргаар тодорхойлох ба илчлэгийн цэвэр утгыг тооцоолох арга - MNS ASTM D 4239, Нүүрс ба коксын дээжид өндөр температурын хоолойт зуух ашиглан хүхрийн хэмжээг тодорхойлох арга. - MNS 5679:2022 стандарт 3. Бүртгэсэн бүртгэл: MNS ISO 17025 стандартын шаардлагад нийцүүлэн лабораторийн анхан шатны болон дэлгэрэнгүй цахим бүртгэлд 23 дээжийн шинжилгээний хариуг бүртгэсэн.<br>Хүрсэн түвшин: 100% | 100% |

| Гурав. Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 4.1. | Төрийн захиргааны болон хүний нөөцийн удирдлагын манлайллыг хангана. | Үйл ажиллагаа ны зардлаар | Хууль, журам, стандартыг мөрдөн ажилласан байна. | 100% | 100% | Хүний нөөцийн удирдлагаар хангах, архив, албан хэрэг хөтлөлтийг тогтмол шуурхай эрхлэн явуулах зорилтын хүрээнд холбогдох хууль, журам, стандартыг 100% хангаж ажилласан. Үүнд: • Тайлангийн хугацаанд 8557 албан бичиг ирснээс 8310 бичгийг шийдвэрлэж, 379 өргөдөл, гомдол ирснээс 354 өргөдөл, гомдлыг шийдвэрлэсэн. Өргөдөл, гомдлын шийдвэрлэлт 93.4% байна. • Хүний нөөцийн үйл ажиллагаатай холбоотой нийт 203 тушаал шийдвэр гарсан. Ашигт малтмал, газрын тосны газрын даргын 2025.02.04-ний өдрийн А/22 дугаар тушаалаар "Ашигт малтмал, газрын тосны газрын албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр"-ийг батлуулсан. • Монгол улсын Засгийн газрын 2025.07.09-ний өдрийн 23-р тогтоолоор байгуулагдсан "Улсын үзлэгийг удирдан зохион байгуулах төв комиссын бүрэлдэхүүн" 2025.10.29-31-ний өдрүүдэд манай байгууллагын ажлын зохион байгуулалт, архив албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд улсын үзлэгийг зохион байгуулсан бөгөөд тус улсын үзлэгт байгууллагын хэмжээнд 90,03%-ийн үнэлгээ авсан. | 90% |
| 4.1.1 | Байгууллагын боловсон хүчний шилжилт хөдөлгөөнийг тогтмол, шуурхай зохион байгуулах | Үйл ажиллагаа ны зардлаар | Шилжилт хөдөлгөөнийг албан хаагчдын 15 хувиас хэтрүүлэхгүй байх | 27.5% | Эхний хагас жилд: 15% Жилийн эцэст: 15% | Хүний нөөцийн үйл ажиллагаатай холбоотой нийт 203 тушаал шийдвэр гарсан байна. Үүнээс шилжилт хөдөлгөөнтэй холбоотой нийт 69 тушаал шийдвэр гарсан. Албан хаагчийн шинээр томилох болон байгууллага | 90% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | дотор шилжүүлэх 53, Шилжүүлэн томилсон 7, чөлөөлсөн 16, Төрийн албаны тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1 дэх хэсэг, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Төрийн албаны зөвлөлийн даргын 2019 оны 34/31 дүгээр хамтарсан тушаалаар батлагдсан “Төрийн жинхэнэ албан хаагчийг өөр албан тушаалд шилжүүлэх, сэлгэн ажиллуулах журам”-ын дагуу холбогдох төрийн байгууллагад 6 албан хаагчийг шилжүүлсэн.<br>Хүрсэн түвшин: 15% | |
| 4.1.2 | Байгууллагын ажилтан, албан хаагчид болон бусад байгууллагаас ирсэн өргөдлийг нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хүрээнд нийгмийн асуудлыг шийдвэрлүүлэн ажиллах | Үйл ажиллагаа ны зардлаар | Ирүүлсэн өргөдөл, хүсэлтийн шийдвэрлэлт хувиар | 100% /121 өргөдөл/ | Эхний хагас жилд: 80% Жилийн эцэст: 100% | Ашигт малтмал, газрын тосны газрын даргын 2025 оны 2 дугаар сарын 4-ний өдрийн А/22 дугаар тушаалаар "Ашигт малтмал, газрын тосны газрын албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр"-ийг батлуулсан. Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн хууль болон Ашигт малтмал, газрын тосны газрын Хөдөлмөрийн дотоод журам, тус агентлагийн албан хаагчдын нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хүрээнд 16 албан хаагчид буцалгүй тусламж, 19 албан хаагчид ажлаас цалинтай чөлөө олгох, тэтгэвэрт гарах 3 албан хаагчийн тэтгэлэг, 9 албан хаагчийн гэр бүлийг дэмжих, 47 бусад албан хаагчдын хоол унааны нөхөн төлбөрийг шинэчлэн тогтоох, төрийн үйлчилгээний албан хаагчдын цалингийн сүлжээг тогтоох зэрэг тушаалын төслүүдийг тус тус боловсруулан хянуулан шийдвэрлүүлсэн. | 90% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Хүрсэн түвшин: 100% | |
